



# СУРАХ БИЧИГТ ХҮНИЙ ЭРХ, ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫН АГУУЛГА ТУСГАХ АРГАЧЛАЛ

**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН



# СУРАХ БИЧИГТ ХҮНИЙ ЭРХ, ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫН АГУУЛГА ТУСГАХ АРГАЧЛАЛ

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

Улаанбаатар хот  
2025

Энэхүү аргачлалыг боловсруулахдаа ЮНЕСКО-оос 2009 онд гаргасан “Promoting Gender Equality through Textbooks. A Methodological Guide” мөн ЮНЕСКО, Боловсролын хяналт-шинжилгээний тайлангийн хавсралт болох “Textbook and Inclusive education” (2020), 2014 онд Боловсрол эвслийн боловсруулсан “Нийгмийн ялгаатай байдлыг сургалтын хөтөлбөр, сурах бичигт тусгах удирдамж”-ийн агуулгыг баримтлан, холбогдох МУ-ын болон ОУ-ын хууль тогтоомжийн хүрээнд боловсруулав.

Боловсруулсан Ц.Ононтуул

Хянасан Я.Мөнхчимэг

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

## ◆ ГАРЧИГ

Хураангуйлсан үгсийн жагсаалт .....	4
Удиртгал .....	5
Үндэслэл .....	7
Хэрэгцээ шаардлага .....	11
Гарын авлагын тухай .....	13
<b>НЭГ ДҮГЭЭР ХЭСЭГ:</b>	
ҮНДСЭН ОЙЛГОЛТ .....	16
<b>ХОЁРДУГААР ХЭСЭГ:</b>	
СУРАХ БИЧГИЙГ ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ БОЛОВСРУУЛАХ НЬ.....	19
<b>ГУРАВДУГААР ХЭСЭГ:</b>	
ХИЧЭЭЛ, ПРАКТИКТ ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ХАНДАХ НЬ .....	37
НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР .....	40

## ХУРААНГУЙЛСАН ҮГСИЙН ЖАГСААЛТ

ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилт
ЗГ	Засгийн Газар
БЕГ	Боловсролын Ерөнхий Газар
ХЭҮК	Хүний эрхийн үндэсний комисс
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ЖСХ	Жендэрт суурилсан хүчирхийлэл
ОУ	Олон улсын
ЖСХ	Жендэрт суурилсан хүчирхийлэл

## ◆ УДИРТГАЛ

Боловсрол бол хүний хөгжлийн төдийгүй нийгмийн хөгжлийн гол амин чанар цаашлаад аливаа улс үндэстний хөгжлийн бодлого, тэргүүлэх салбар, чиглэлүүдийн нэг мөн. Монгол Улсын Үндсэн хуулиар хүний эрх, тэр дундаа боловсрол эзэмших үндсэн эрхийг баталгаажуулсан. Үндсэн хуулийн хоёрдугаар бүлгийн 16-р зүйлийн 7-д “МУ-ын иргэн бүр сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг үнэ төлбөргүй олгоно”<sup>1</sup> хэмээн зааснаар хүн бүрийн сурч боловсрох эрхийг баталгаажуулсан төдийгүй боловсрол дахь хүний эрх, жендэрийн эрх тэгш байдлыг хүлээн зөвшөөрч, төрийн хүлээх үүргийг тодорхойлсон.

2023 онд батлагдсан Боловсролын ерөнхий хуулийн 4.1-д Монгол Улсын боловсролын зорилго нь хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, насан туршдаа суралцаж, ажиллах, ёс суртахуунтай, сайн зан чанартай иргэнийг төлөвшүүлэхэд оршино<sup>2</sup> гэж заасан нь хүүхэд бүрийн сурч боловсрох тэгш эрхийг дахин баталгаажуулахын зэрэгцээ боловсролоор дамжуулан жендэрийн тэгш байдалд хүрэх эрх зүйн таатай орчныг бүрдүүлж өгчээ. Түүнчлэн тус хуулийн 10-р зүйлд суралцагчийн эрх, үүргийг тодорхойлохдоо эрүүл, аюулгүй, жендэрийн тэгш байдлыг хангасан орчин, нөхцөлд суралцах, чадамжаа үнэлүүлэх, хүлээн зөвшөөрүүлэх, дүйцүүлэх, баталгаажуулах, хөгжлийн бэрхшээлтэй суралцагч нь бусад суралцагчийн адил боловсрол эзэмших тэгш боломж, нөхцөлөөр хангагдах, ялгаатай хэрэгцээнээс үл хамааран чанартай боловсрол эзэмших тэгш боломжоор хангагдах зэрэг эрхийг баталгаажуулж бусдын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, хүний эрх, эрх чөлөөг дээдэлж, ялгаварлан гадуурхах, дарамтлах, доромжлох, нэр төр, алдар хүндийг нь гутаах үйлдэл гаргахгүй байхыг заасан байна. Өөрөөр хэлбэл энэ нь боловсролын бүхий л орчинд хүний эрх, жендэрийн эрх тэгш байдлыг хангахыг баталгаажуулж бүх төрлийн ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэл, дарамтыг үл хүлцэн тэвчих үүрэг хүлээсэн байна. Монгол Улсад боловсролын тогтолцоо нь албан ба албан бус боловсролын нэгдэл байх бөгөөд сургуулийн өмнөх болон бага, дунд, мэргэжлийн боловсрол, дээд боловсролоос бүрддэг. Энэхүү боловсролын бүхий л явцад ерөнхий боловсролын сургуулийн сурах бичиг нь мэдээллийг дамжуулах, шинэ мэдлэгийг олгох, сурагчдыг амьдралд бэлтгэх чухал хэрэгсэл болж өгдөг.

Нийгмийн бүхий л мэдээ, мэдээллийн хэрэгсэл, мэдлэгийн эх сурвалжаас албан боловсролын гол хэрэглэгдэхүүн болсон сурах бичиг нь хүүхэд, залуучуудыг төлөвшүүлэхэд голлох байр суурийг эзэлнэ. Сурах бичиг нь шинжлэх ухааны танин мэдэхүйн мэдлэгийг тээгч төдийгүй нийгмийн үнэт

1 Монгол Улсын Үндсэн хууль

2 Боловсролын ерөнхий хууль

зүйлс, улс төрийн үзэл баримтлал, түүх, ертөнцийг үзэх үзлийг төлөвшүүлэх гол эх сурвалж юм. Багш, суралцагчид, эцэг эхчүүд сурах бичгийг үнэн зөв буюу баримт нотолгоонд суурилсан, тэнцвэртэй, шинжлэх ухааны, сурган хүмүүжүүлэх арга зүйн хамгийн сүүлийн үеийн ололтод суурилсан, хамгийн найдвартай, бодитой мэдээллийн эх сурвалж хэмээн итгэдэг. Зарим тохиолдолд сурах бичиг хүүхдийн анхны төдийгүй цорын ганц унших боломжтой ном байх нь бий.<sup>3</sup>

Ерөнхий боловсролын сурах бичиг нь сурагчдын нас, сэтгэхүйн онцлогт тохирсон бүтэцтэй байж, тэдний сурах чадварыг хөгжүүлж, аливаа зүйлийг ойлгох, бодитоор харж дүгнэх, сэтгэн бодох боломжийг бүрдүүлэх цаашлаад зөвхөн хичээлийн мэдлэг төдийгүй нийгэмд хэрхэн амьдрах, бусдыг хүндэтгэх, хамтран ажиллах, асуудал шийдвэрлэх чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн байх ёстой. Улмаар “Дэлхийн иргэн байх боловсрол нь хүний эрх, жендэрийн тэгш эрх, оролцоо, үл ялгаварлан гадуурхах, иргэдийг эрх мэдэлжүүлэх, үл хүчирхийлэх, ялгаатай байдлыг хүндэтгэх Дэлхий нийтийн түгээмэл зарчмуудад суурилж нийгмийн болон хувь хүний эерэг өөрчлөлтийг авчирахад чиглэнэ”.<sup>4</sup>

Сурах бичгийн чанар нь боловсролын чанарт шууд нөлөөлдөг. Өнөө үед сурах бичиг нь зөвхөн мэдээлэл дамжуулагч хэрэгсэл бус, харин сурагчдын өөрийгөө илэрхийлэх, асуудал шийдвэрлэх, жендэрийн мэдрэмжтэй байх, байгаль орчноо хайрлах зэрэг олон талт ойлголтуудыг төлөвшүүлэх зорилготой. Иймд ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгүүд нь сурагчдын танин мэдэхүйн хэрэгцээг хангахын зэрэгцээ жендэрийн тэгш байдал, олон янзат байдлыг ойлгох, хүлээн зөвшөөрөх, хүний эрхийг дээдлэх зэрэг нийгмийн чухал үнэт зүйлсийг хүүхдийн оюунд суулгах, ирээдүйн иргэнийг бэлтгэх хариуцлагатай хэрэгсэл юм. Сайн боловсруулсан сурах бичиг нь сурагчдад дэлхий ертөнцийг ойлгох, өөрийгөө хөгжүүлэх, бусдыг хүндэтгэх, ёс суртахууны төлөвшлийг дэмжих гүүр болно.

Сурах бичиг нь чухамдаа нийгмийг дагаж хөгжих бус, нийгмийн хөгжлийг түүчээлж түрүүлж алхах нь зүй. Гэсэн хэдий ч сурах бичгийн агуулгыг жендэрийн, хүний эрхийн линзээр тольдвоос шүүмжлэлтэй зүйл бишгүй олон. Тиймээс сурах бичгийг нийгмийн хөгжилд нийцүүлэн сайжруулах, цаг үеийн хэрэгцээнд нийцүүлэн хөгжүүлэх нь боловсролын тогтолцооны цөм бөгөөд ирээдүйг өөрчлөх хүчтэй хэрэгсэл байхаас өөр аргагүй. Сурах бичигт жендэрийн эрх тэгш байдлын агуулга тусгах аргачлалыг ашиглах нь сурах бичгийн төдийгүй боловсролын салбарын хөгжлийг дэмжих арга хэрэгсэл болох боломжтой юм. Хүүхдүүдийг жендэрийн хэвшмэл ойлголтоос ангид өсгөж төлөвшүүлэх, ирээдүйд тэгш байдлыг эрхэмлэгч, хариуцлагатай иргэн болгон бэлтгэхэд чухал ач холбогдолтой. Жендэрийн мэдрэмжтэй боловсруулсан сурах бичгүүд нь хүүхдүүдийн сэтгэлгээ, үнэт зүйлс, нийгмийн хандлагыг өөрчлөх гол хөшүүрэг болж чадна.

3 “Нийгмийн ялгаатай байдлыг сургалтын хөтөлбөр, сурах бичигт тусгах удирдамж”, Боловсрол эвсэл, 2017 он

4 Дэлхийн иргэн байх боловсрол гэх ойлголтын олон улсын эрх зүйн хэм хэмжээний үндэс нь ЮНЕСКО-ийн 1974 онд батласан “Хүний эрх болон үндсэн эрх чөлөөтэй холбоотой олон улсын ойлголцол, хамтын ажиллагаа, энх тайван болон боловсролын тухай зөвлөмж”-д тусгагдсан.

## ◆ ҮНДЭСЛЭЛ

Одоогоор Монгол улсад ашиглагдаж буй ЕБС-ийн сурах бичгийн агуулгыг хүний эрх, жендэрийн мэдрэмжтэй боловсруулах хэрэгцээ шаадлагатай байгааг олон судалгааны үр дүнгээс бэлхэн харж болно.

Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулийн 12.5-д “Ерөнхий боловсролын сургууль, сургалтын бусад байгууллагад хэрэглэдэг ном, сурах бичиг болон сургалтын хэрэглэгдэхүүн нь жендэрийн эрх тэгш байдлыг үгүйсгэсэн агуулгатай байж үл болно.” хэмээн заасныг үндэслэн 2021 онд уг хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлсэн тайланд уг заалтыг үнэлэхдээ “Сурах бичгийн зураг, дүрслэл, эхэд эрэгтэйчүүдийн дүр хэт давамгайлж байгаа ба эрэгтэй, эмэгтэйчүүдийн дүр үүрэг, сэтгэл зүйн шинжүүдийг жендэрийн хэвшмэл ойлголтоор өрөөсгөл хандлагаар дүрсэлсэн нь нэлээд хувийг эзэлж байгаа нь сурагчдад жендэрийн эерэг соёл төлөвшин хөгжихөд хүндрэл учруулж болзошгүй байна... Жендэрийн эрх тэгш байдлын боловсролд сөрөг нөлөө үзүүлэхүйц сургалтын хэрэглэгдэхүүнийг ашиглахаас урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдээгүй байна” хэмээгээд улмаар “ЕБС, сургалтын бусад байгууллагад хэрэглэдэг ном, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнд жендэрийн эрх тэгш байдлыг үгүйсгэсэн агуулга байгаа эсэхэд жендэрийн чиглэлээр мэргэшсэн судалгааны байгууллагуудаар дүн шинжилгээ хийлгэдэг болох, сурах бичгийн стандартад нас хүйс, сэтгэхүйн онцлогт тохирсон жендэрийн агуулгыг нарийвчлан тусгаж, сурах бичиг зохиогчид болон редакторуудыг жендэрийн чиглэлээр бэлтгэх, чадавхжуулах” хэмээх зөвлөмж<sup>5</sup> өгчээ.

Мөн түүнчлэн 2023 онд Хүний Эрхийн Үндэсний Комиссын захиалгаар 6-12 дугаар ангийн Иргэний ёс зүйн боловсрол сурах бичигт дүн шинжилгээ, Боловсрол эвслээс 2014 онд сурах бичигт хүний эрх, жендэрийн эрх тэгш байдал, олон соёлын харилцан ойлголцол, ялгаатай байдлыг ойлгох, хүндэтгэх агуулга туссан эсэхэд хяналтын уншлага, 6-12-р ангийн Иргэний ёс зүйн боловсрол сурах бичгийг агуулга текст, дүрслэл, зураг аль алиныг хамааруулж, хүний эрх, жендэрийн эрх тэгш байдал, тэгш хамруулалт, олон талт ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх, тэгш байдлын агуулга хэрхэн илэрч буйд дүн шинжилгээ хийсэн байдаг. Дүн шинжилгээний явцад гарсан зарим жендэрийн эрх тэгш байдлын агуулгатай холбоотой дүгнэлтүүдээс дурьдвал:<sup>6</sup>

- *Иргэний ёс зүйн боловсрол сурах бичигт зурган дүрслэлийн 6-12-р ангийн нийт сурах бичгийн 70 гаруй хувийг эрэгтэй дүр эзэлж байсан бол эмэгтэй дүр 30 орчим хувийг эзэлж байна.*

5 Монгол улсад жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, 2021 он, Жендэрийн Үндэсний хороо <https://nli.gov.mn/?p=8320>

6 ЕБС-ийн 6-12-р ангийн “Иргэний ёс зүйн боловсрол” сурах бичгийн агуулгад хүний эрхийн үүднээс хийсэн дүн шинжилгээ, ХЭҮК-ын захиалгаар Боловсрол эвсэл хийв. 2023 он

- Эрэгтэй хүн, эрэгтэй хүүхдийг ухаалаг, тууштай, хөдөлмөрч байдлаар дүрсэлсэн бол эмэгтэй хүн, охин хүүхдийг халамжлагч, уян зөөлөн сэтгэлтэй гэсэн жендэрийн хэвшмэл байдлаар дүрсэлжээ.
- Нийгмийн цөөнх бүлэг, нийгмийн ялгаатай байдлыг огт дүрслээгүй бөгөөд хөгжлийн бэрхшээл, үндэс угсаа, жендэр, бэлгийн цөөнх бүлгийг дүрсэлсэн зураглал, текст, жишээ байхгүй.
- Мөн өнгөний хувьд эрэгтэйг цэнхэр, эмэгтэйг ягаан өнгөөр ихэвчлэн дүрсэлсэн байна.
- Эрэгтэй дүрүүд зохиолч, киноны гол дүр, философич, улс төрч, бизнесмен, шашны зүтгэлтэн, соён гэгээрүүлэгч, түүхэн зүтгэлтэн, хаан гэх мэт олон янзат байдлаар дурдагдсан бол эмэгтэй дүрүүд хатан, эх, домгийн дүрээр дурдагдсанаас гадна эх зохиолын гол дүр болж бичигдсэн Бадам бүсгүй нь бусдын аяыг дагадаг, өөртөө итгэлгүй, өөрийн гэсэн үзэл бодолгүй нэгэн мэтээр дүрслэгджээ.
- Сурагчдын даалгаварт өгсөн дасгал ажлууд нь соёл, уламжлалд туссан хэвшмэл ойлголт, өрөөсгөл хандлагыг илэрхийлсэн үг, хэллэг, агуулгаар дүрсэлж, жендерээр ялгаварлан гадуурхжээ.
- Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулийн 12.5-д “Ерөнхий боловсролын сургууль, сургалтын бусад байгууллагад хэрэглэдэг ном, сурах бичиг болон сургалтын хэрэглэгдэхүүн нь жендэрийн эрх тэгш байдлыг үгүйсгэсэн агуулгатай байж үл болно.” заалтыг зөрчжээ.
- Бүх сурах бичигт хөгжлийн бэрхшээлтэй хүнийг дүрсэлсэн зураг, дүрслэл байхгүй.
- Жендэрийн шударга ёс, олон талт ялгаатай байдлыг талаар агуулга хангалтгүй байна.
- Жендэрийн шударга ёс, олон талт ялгаатай байдлыг талаар сурах бичгийн агуулга хангалтгүй байна. Охид, эмэгтэйчүүдийн төлөөлөл хангалтгүй, хүйсийн, үүргийн хувьд тэнцвэртэй дүр дүрслэл үгүй, эрэгтэй эмэгтэй хүний жендэрийн үүрэг, ажил мэргэжил, шинж чанарын хувьд хэвшмэл, өрөөсгөл, тогтсон гадуурхлаар илэрхийлэгдсэн, хортой, шударга бус хүлээлтүүд<sup>58</sup>ийг аль аль хүйсэд тусгасан байна.

Дээрх дүн шинжилгээнүүдэд үр дүнгээс харахад сурах бичгийн агуулгад жендэрийн хэвшмэл ойлголтыг бэхжүүлсэн, хүний эрх, ардчилал, шударга ёсны үзэл санаанд харшилсан, соёлын олон янз байдлыг үгүйсгэсэн, нийгмийн амьдрал дахь бүтцийн ялгаа, ажил үүргийн хэвшмэл хуваарилалтыг өөгшүүлсэн, хүйсээр ялгаварлан гадуурхсан агуулга байгааг тодорхойлсон байна.

Тэгвэл Монгол улс боловсролын салбарт, тодруулбал сурах бичигт хүний эрх, жендэрийн эрх тэгш байдлын агуулгыг тусгах, хангах, хамгаалах чиглэлээр ямар бодлого, арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэв. Тоймлон үзвэл:

- 1992 оны **Монгол Улсын Үндсэн хуулиар** хүн бүрийн сурч боловсрох эрхийг баталгаажуулж, боловсролын салбар дахь хүний эрх, жендэрийн эрх тэгш байдлыг баталгаажуулав.
- 2002 онд шинэчлэгдэн батлагдсан **Боловсролын тухай хууль 2020, 2022** онуудад шинэчлэгдэж, боловсролын чанар, хүртээмж, сурч боловсрох тэгш боломжийг нэмэгдүүлэх чиглэлд анхаарч ажилласан. Тус хуульд боловсрол нь хүний хөгжил, хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн, ардчилсан, хүмүүнлэг нийгмийн үндэс суурь болохыг онцолсон. Улмаар Боловсролын үндсэн зарчмууд дунд ялгаварлан гадуурхалгүй, суралцагчийн онцлогт нийцсэн, олон хувилбартай, нээлттэй байх зарчим хадгалагдаж, жендэрийн тэгш байдлыг дэмжих эрх зүйн суурь орчин бүрдсэн байна.
- 2011 онд батлагдсан **Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль** нь боловсролын салбарт жендэрийн тэгш байдлыг хангуулахтай холбоотой заалтуудыг нарийвчлан тусгасан. Ингэхдээ 12 дугаар зүйл. Соёл, боловсролын салбар дахь жендэрийн эрх тэгш байдлын баталгаа<sup>7</sup>: -г хуульд тусгахдаа:
 

“12.5. Ерөнхий боловсролын сургууль, сургалтын бусад байгууллагад хэрэглэдэг ном, сурах бичиг болон сургалтын хэрэглэгдэхүүн нь жендэрийн эрх тэгш байдлыг үгүйсгэсэн агуулгатай байж үл болно” гэсэн заалт нь боловсролын хөтөлбөр, хэрэглэгдэхүүний агуулга дахь жендэрт холбогдох шаардлагыг тодорхой болгож өгсөн байна. Хэдийгээр жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд туссан боловч боловсролын салбарын шинэчлэл, хөтөлбөрүүдэд уг хуулийн үзэл санаа төдийлөн бодитой тусгагдаагүй хэвээр байгаа нь мэргэжилтнүүдийн дунд шүүмжлэл дагуулсаар байна.
- 2023 онд батлагдсан **Боловсролын ерөнхий хуульд** албан боловсролын агуулга нь суралцагчийн нас, хөгжлийн онцлог, авьяас, сонирхол, хувь хүний болон нийгмийн хэрэгцээ, үндэсний соёл, өв уламжлал, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн хандлагад нийцүүлэн боловсролын зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэнэ хэмээн зааж албан боловсролын хөтөлбөр, агуулгад 14.4.3. хүний эрхийн боловсрол, жендэрийн эрх тэгш байдал<sup>8</sup>-ын агуулгыг заавал тусгаж, боловсролын сургалтын байгууллага өмчийн хэлбэр харгалзахгүй хэрэгжүүлнэ хэмээжээ.

#### Үндэсний бодлого, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн байдал

- **Боловсрол” үндэсний хөтөлбөр (2010–2021)** хэрэгжиж дууссан бөгөөд шинэчлэгдсэн хувилбар 2023 онд боловсруулагдаж, одоогоор батлагдаагүй байна. Хуучин хөтөлбөрийн стратегийн зорилтод жендэрийн тэгш байдлыг хангуулахтай холбоотой зорилго, арга хэмжээг тусгасан боловч хэрэгжилтийн

<sup>7</sup> Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль

<sup>8</sup> Боловсролын ерөнхий хууль

шалгуурт тодорхой үзүүлэлтүүд багтаагүй, үнэлгээний хэсэгт үр дүнг тодорхойлоогүй орхигдуулсан нь шүүмжлэлтэй хэвээр байна.

- **Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого” (2014–2024) хэрэгжилтийн хугацаа дууссан бөгөөд шинэ бодлогын баримт бичгийг боловсруулж буй.** Энэхүү баримт бичгийн 12-р зүйлд жендэрийн тэгш байдлыг хангах бодлого боловсруулах, үе шаттай хэрэгжүүлэхээр заасан ч, хэрэгжилт хангалтгүй байна. Түүнчлэн бодлогын хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтэд жендэртэй холбоотой тодорхой хэмжүүр, шалгуур ороогүй.
- **Тогтвортой хөгжлийн зорилт ба үндэсний стратеги 2016 онд батлагдсан Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 нь боловсрол, хүний хөгжил, жендэрийн тэгш байдалд анхаарсан үндэсний бодлого бөгөөд:**
  - Хүний хөгжилд суурилсан, хүртээмжтэй өсөлт;
  - Насан туршийн боловсролын тогтолцоо;
  - Жендэрийн тэгш оролцоо, адил тэгш хүртээмж зэрэг зорилтуудыг тусгасан. Гэвч

2025 оны байдлаар эдгээр зорилтуудын хэрэгжилт хангалтгүй бөгөөд боловсрол дахь жендэрийн тэгш байдлыг хангах тусгайлсан үйл ажиллагаа, хэмжүүр бүхий шинэ хөтөлбөр, бодлогын баримт бичиг одоогоор батлагдаагүй байна.

Дээрх олон талт хүрээнд боловсрол дахь жендэрийн тэгш байдлын агуулгыг хуулиар баталгаажуулсан ч бодлогын түвшинд хэрэгжихүйц тусгайлсан арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, нөлөөллийн үнэлгээ дутагдалтай хэвээр байна. Хүний эрх, жендэрийн тэгш байдлыг дэмжсэн агуулга нь зөвхөн боловсролын төдийгүй нийгмийн бүх салбарт эерэг өөрчлөлтийг бий болгоход чухал. Жишээлбэл, шийдвэр гаргах түвшний хүмүүсийг эрэгтэй, эмэгтэй аль алинд нь адил харуулах нь сурагчдад нийгэмд эмэгтэйчүүдийн оролцоо чухал гэдгийг ойлгуулахад тусалдаг<sup>9</sup>. Мөн түүнчлэн жендэрийн хэвшмэл ойлголтууд болон ялгаварлан гадуурхах үзлийг багасгахын тулд сурах бичигт жендэрийн агуулгыг зөв тусгах шаардлагатай. Үүнийг хэрэгжүүлснээр хүүхдүүдийн хандлага, үзэл санаа, зан төлөв илүү хүртээмжтэй, хүлцэнгүй болж хөгжих боломжтой байдаг<sup>10</sup>.

ОИГ.МН  
СУДАЛГААНЫ САН

9 ИЕЗБ-сурах-бичгийн-дүн-шинжилгээний тайлан

10 Нийгмийн ялгаатай байдлыг сургалтын хөтөлбөр, сурах бичигт тусгах удирдамж

## ◆ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

НҮБ болон ЮНЕСКО зэрэг байгууллагууд жендэрийн эрх тэгш байдлыг боловсролд тусгахыг улс орнуудад зөвлөж, үүнийг боловсролын салбарт нэвтрүүлэх аргачлалуудыг боловсруулсаар байна. Монгол Улсын боловсролын бодлогын баримт бичгүүд ч энэ чиглэлд уялдаатай хэрэгжих ёстойг онцолсон байдаг. Иймд сурах бичигт жендэрийн эрх тэгш байдлыг тусгаж, хүүхэд бүрийг ялгаваргүй, тэгш эрхтэй нийгэмд оршин амьдрахад бэлтгэх нь нэн чухал юм. Энэхүү өөрчлөлт нь нийгмийн тогтвортой хөгжил, хүмүүнлэг үнэт зүйлсийг төлөвшүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулна. Түүнчлэн, хуучин бодлогын хөтөлбөрүүдийн хугацаа дуусаж, шинэ бодлого боловсруулах явц удаашралтай байгаа нь жендэрийн тэгш байдлыг бодит байдалд хэрэгжүүлэхэд саад болж байна. Иймээс боловсролын салбар дахь жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилт, уялдааг сайжруулах шинэчлэл шаардлагатай хэвээр байна.

Өмнө дурдсанчлан, дүн шинжилгээний үр дүнгүүдээс харахад сурах бичигт жендэрийн эрх тэгш байдлын агуулга тусгах аргачлал хэрэгцээтэй бөгөөд нэгдсэн ойлголт, аргачлал ашиглан боловсруулах нь чухал байна. Хүний эрх жендэртэй холбоотой агуулгыг сургалтын хөтөлбөрт шууд болон дам байдлаар тусгах боломжтой. Сурах бичгийн агуулгыг жендэрийн мэдрэмжтэй боловсруулах хэрэгцээ шаардлагыг дараах хүрээнд тайлбарлавал:

### 1. Жендэрийн тэгш бус байдлын асуудал

Монгол Улсад жендэрийн эрх тэгш байдлын хүрээнд зарим ахиц дэвшил гарч байгаа хэдий ч нийгмийн олон салбарт жендэрийн тэгш бус байдал бат бэх оршсоор байна. Жишээлбэл:

- Мэргэжил сонголтод жендэрийн хэвшмэл ойлголт нөлөөлдөг. Сурах бичигт эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн үүрэг хариуцлага, мэргэжлийг хэвшмэл байдлаар харуулсан жишээнүүд олноор багтдаг нь сурагчдын хандлагад хэвшмэл ойлголтоор нөлөөлж, тэднийг өөрийн чадавх, сонирхлыг хөгжүүлэхээс хязгаарлах магадлалтай.
- Жендэрийн хэвшмэл ойлголт нь эмэгтэйчүүдийг гэрийн ажил хийх, асрахуйн гол үүрэг хүлээгч байхыг шаарддаг бол эрэгтэйчүүдийг хөдөлмөрийн зах зээлд давамгайлах зарим тохиолдолд ихэвчлэн биеийн хүчний ажил хийх ёстой гэсэн хандлагыг түгээж байна.

### 2. Хүүхдийн хөгжлийн олон талт байдлыг дэмжих шаардлага

Сурах бичигт жендэрийн эрх тэгш байдлын агуулга дутагдвал охид, хөвгүүд өөрийн хүсэл сонирхол, авьяасаа хөгжүүлэхэд саад учирч, жендэрийн аливаа ялгаварлалыг хүлээн зөвшөөрөх магадлал нэмэгдэнэ. Тухайлбал:

- Охидыг шинжлэх ухаан, технологи, инженерчлэл, математикийн (STEM) салбарт сонирхлоо хөгжүүлэхээс татгалзах, хойш татах
- Хөвгүүдийг урлаг, хүмүүнлэгийн чиглэлээр өөрийгөө илэрхийлэх боломжийг хязгаарлах

Эдгээр нь хүүхдүүдийн ирээдүйд нөлөөлөхөөс гадна нийгэмд мэргэжлийн боловсон хүчний тэнцвэргүй байдлыг бий болгож, бүтээмжийг бууруулна.

### **3. Нийгмийн үнэт зүйлсийг төлөвшүүлэх шаардлага**

Жендэрийн мэдрэмжтэй сурах бичиг нь хүүхдүүдэд бусдыг хүндлэх, ялгаварлан гадуурхахгүй байх, нийгмийн шударга байдлыг ойлгоход тусалдаг. Монгол Улсын боловсролын систем нь зөвхөн мэдлэг өгөх бус, хүний эрх, жендэрийн тэгш байдлыг дээдлэх үнэт зүйлсийг төлөвшүүлэх зорилготой байх хэрэгтэй.

### **4. Олон улсын туршлага, бодлогын шаардлага**

Монгол Улс нь НҮБ-ын Тогтвортой Хөгжлийн Зорилтууд болон жендэрийн тэгш байдлыг хангах олон улсын гэрээ, конвенцид нэгдэн орсон. Энэ хүрээнд боловсролын систем нь жендэрийн тэгш байдлыг дэмжихэд хувь нэмэр оруулах шаардлагатай. Сурах бичиг нь энэхүү зорилтыг хэрэгжүүлэх гол хэрэгсэл байж чадна.

### **5. Одоогийн сурах бичигт тулгамдаж буй асуудлууд**

Монголын ерөнхий боловсролын сурах бичгүүдэд:

- Эрэгтэй, эмэгтэй дүрүүдийн дүрслэл тэгш бус байдалтай байдаг.
- Агуулга, жишээнүүд нь жендэрийн хэвшмэл ойлголт, хэм хэмжээг илтэд тусгасан байдаг.
- Нийгэм, цаг үеийн өөрчлөлтөд нийцсэн уян хатан жендэрийн мэдрэмж дутагдаж байна. Эдгээр асуудлууд нь хүүхдүүдэд жендэрийн хэвшмэл хандлагыг бататгах эрсдлийг дагуулдаг.

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

## ◆ ГАРЫН АВЛАГЫН ТУХАЙ

Энэхүү аргачлал нь сурах бичгийн агуулгыг текст, дүрслэл, зураг, дасгал зэрэг бүх хэсэгт жендэрийн эрх тэгш байдал болон олон талт ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрсөн байдлаар тусгах боломжтой хялбаршуулсан ерөнхий хүрээг санал болгож байна. Сурах бичиг боловсруулах үйл явцад оролцож буй бүх мэргэжилтэн жендэрийн асуудлаар гүнзгий мэдлэгтэй байх шаардлагагүй ч, энэхүү аргачлал, чиглэл, анхаарах агуулгыг баримтласнаар жендэрийн мэдрэмжтэй, эрх тэгш байдлын агуулгыг хангасан сурах бичиг боловсруулах бүрэн боломжтой. Тухайлбал:

- ✓ Таны боловсруулж буй сурах бичигт хүүхдийн эрхийг хүндэтгэсэн, хүний эрхийг хамгаалах, жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар агуулга тусгасан эсэхийг нягтлах;
- ✓ Сурах бичигт хүмүүсийн ажил үүрэг, хариуцлагын талаарх хэвшмэл ойлголтыг хадгалж, дамжуулахаас зайлсхийх;
- ✓ Сургалтын агуулга нь хүүхдийн нас, танин мэдэхүйн хөгжил, суралцах хэв маягт нийцсэн эсэх;
- ✓ Сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнээр дамжуулан хүчирхийллийг дэмждэггүй байх төлөвшлийг олгох, бусдыг хүндлэх, ойлгох агуулга тусгасан эсэх;
- ✓ Ялгаварлан гадуурхалтаас ангид байх, олон талт байдлыг хүлээн зөвшөөрөх тухай тусгасан эсэх; Хүний, бүлгийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх тухай ойлголт, мэдээллийг тусгасан эсэх;
- ✓ Жендэрийн эрх тэгш байдал, нийгмийн тэгш хамруулалт (үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, шашин шүтлэг, боловсрол, үндэсний цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй иргэн)-ын талаар агуулга, дүрслэлийг тусгасан байдал;
- ✓ Үндэсний соёл, уламжлалд хэвшмэл ойлголт, өрөөсгөл хандлагыг илэрхийлсэн үг хэллэг, агуулга тусгасан байдал (ялгаварлан гадуурхсан, дорд үзсэн хандлага бүхий зан заншил); Сурах бичгийн агуулгад нутгийн аялга үг, хараал, доромж үг, хэллэг хэрэглэсэн эсэх;
- ✓ Нийгмийн олон талт оролцооны арга хэрэгслийн талаарх ойлголт, мэдээллийг тусгасан эсэх;
- ✓ Зураг дүрслэл дэх хүйсийн болон бусад бүлгийн харьцаа, тэнцвэрт байдлыг хангасан эсэх;
- ✓ Зураг дүрслэл дэх дүр, үүргийг илэрхийлсэн байдал, хүмүүсийн олон талт төлөөллийг сонгосон эсэх; (Жишээ нь: Эрэгтэй хүнийг дарга,

удирдагчаар, эмэгтэй хүнийг багш, эмчээр гол төлөв төлөөлүүлдэг, хийх ажлын хувьд багшлах болон гэрийн ажил цэвэрлэгээний ажил хийж байгаагаар эмэгтэйчүүдийг дүрсэлсэн байдаг. Эрдэмтэн, судлаач, ажилчин зэрэг олон талт төлөөллөөр илэрхийлэх);

- ✓ Зураг дүрслэлд үндэсний цөөнх, олон үндэстэн ястан, өөр бүлгийн талаар тусгасан эсэх;
- ✓ Зураг дүрслэл дэх өнгөний сонголт;
- ✓ Зураг дүрслэлийн тайлбар, үгийн сонголт зэргийг анхаарах нь жендэрийн эрх тэгш байдлын агуулга тусгах ажлын цөм хэсгүүд юм.

Өөрөөр хэлбэл Агуулгын түвшинд: Жендэрийн тэгш байдал, хүний эрх, ардчиллын үнэт зүйлсийг тодорхой ухагдахуун, кейсээр тайлбарлан оруулах, эсвэл зөв мэдлэг ойлголтод чиглүүлэх, сурах бичгийн бүлэг бүрд жендэрийн мэдрэмжтэй жишээ, асуулт, даалгавар тусгах, жендэрийн тэгш байдлын талаарх ойлголт, мэдлэг, хандлага, чадварыг бий болгох бүтээлч даалгавар боловсруулж оруулах нь чухал. Түүнчлэн Дүрслэлийн түвшинд: Зураг, график, дүрслэлд эмэгтэй, эрэгтэй, бусад бүлгийн төлөөллийн тэнцвэртэй дүрслэл, төрөл бүрийн ажил үүргийн хуваарилалт оруулах (*жишээ нь эмэгтэй удирдагч, бэлгийн цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй сурагчийн дүрүүдийг багтаах*), орчин үеийн эх сурвалжийг ашиглан олон талт байдлыг тусгах, зохиогчийн эрхийг хүндэтгэх, зүй зохистой, гоо зүйтэй зураг дүрслэл ашиглахаас эхэлнэ.

### **Зорилго**

Сурах бичгийн агуулгад жендэрийн эрх тэгш байдлыг тусгах замаар хүүхэд, залуучуудад жендэрийн тэгш байдлыг эрхэмлэх, аливаа жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалт, дарамт хүчирхийллийг хүлцэн тэвчдэггүй байх үнэт зүйлсийг төлөвшүүлэх замаар сургалтын чанарыг сайжруулах, нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах зорилготой.

### **Зорилт**

- Сурах бичигт жендэрийн мэдрэмжтэй агуулга, тохиолдол, зураг дүрслэл оруулахад анхаарах аргачлал боловсруулах
- Эрэгтэй, эмэгтэй хүүхдүүдийн аль алинд эерэг нөлөө үзүүлэх, эрх тэгш боломжийг харуулах агуулгыг тусгахад анхаарах
- Олон талт байдлыг хүлээн зөвшөөрөх, хамтран ажиллах хандлага, үнэт зүйл бий болгоход уриалах
- Жендэрийн мэдрэмжтэй сурах бичгүүдээр дамжуулан ирээдүйн жендэрийн тэгш байдлыг хангах суурийг бий болгоход хувь нэмэр оруулах
- Охид, хөвгүүдийн аливаа ялгаварлалгүйгээр эрх тэгш хөгжих орчныг бүрдүүлэхэд анхаарах
- Тогтвортой хөгжлийн зорилтуудын жендэрийн эрх тэгш байдлыг хангах 5-р зорилт болон боловсролын чанарыг сайжруулах 4-р зорилтыг дэмжих.

Хууль, журам, тунхаглал зэрэг холбогдох зарим баримт бичгийн жагсаалт буюу аргачлалыг боловсруулахад ашигласан баримт бичгүүд

Баримт бичгийн нэр	Агуулга
Жендэрийн эрх тэгш байдлын тухай хууль (2011)	12.5-р зүйлд “сурах бичиг жендэрийн тэгш байдлыг үгүйсгэсэн агуулгатай байж үл болно” гэж заасан
Монгол Улсын Үндсэн хууль	Хүн бүр эрх тэгш, шашин шүтэх эс шүтэх эрхтэй (14.1, 14.2, 16.15, 9.2)
Хүний эрхийн түгээмэл тунхаглал	Боловсрол нь хүний эрх, тэгш байдлыг дэмжих ёстой (26-р зүйл)
ИБУТЭОУП (Олон улсын иргэний болон улс төрийн эрхийн пакт)	Эцэг эхийн итгэл үнэмшлийн дагуу боловсрол эзэмшүүлэх эрхийг хүндэтгэх (18.4-р зүйл)
ЕБС-ийн сурах бичигт тавих стандарт (MNS 2054:2008)	Сурах бичгийн зохиомж, агуулгын үндсэн шаардлагууд
Суурь боловсролын хөтөлбөр (БШУЯ, 2019)	Ерөнхий боловсролын суурь агуулгын үндэс
UNESCO – Promoting Gender Equality through Textbooks (2009)	Сурах бичигт жендэрийн мэдрэмжтэй үнэлгээ хийх аргачлал

#### Хүрэх үр дүн

- Сурагчид жендэрийн хэвшмэл ойлголтоос ангид, хүйсээс үл хамааран охид хөвгүүд тэгш боломжоор хангагдаж, өөрийн хүсэл, чадавхыг бүрэн дүүрэн хөгжүүлэх нөхцөл бүрдэж жендэрийн эрх тэгш байдлыг дэмжинэ.
- Боловсролын салбарт жендэрийн мэдрэмжтэй хандлага бүрэлдэж, сурагчдын сонирхлыг дэмжсэн сурах орчин бүрдэж, сурах бичиг нь зөвхөн хичээлийн хэрэгсэл бус, нийгмийн хөгжлийг дэмжигч хүчтэй хэрэгсэл болж чадна.
- Сурагчид жендэрийн тэгш байдлын тухай ойлголттой болж, нийгэмд гарч буй аливаа хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтын эсрэг үйл ажиллагаанд оролцох дуу хоолойгоо илэрхийлэх чадвартай иргэд болж төлөвшинө.
- Монголын боловсролын систем нь жендэрийн эрх тэгш байдлыг дэмжих олон улсын зорилтуудтай нийцсэн, тэдгээрийг хэрэгжүүлэгч гол хүчин зүйл болно. Аргачлалд дурдагдаж буй нэр томъёоны тайлбаруудыг холбогдох байгууллагын гаргаснаар болон хуулийн хүрээнд тодорхойлсны дагуу хавсралтаар оруулсан бөгөөд энэхүү хэсэгт ерөнхий ойлголтуудын мэдээллийг хүргэж байна.

## НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: ҮНДСЭН ОЙЛГОЛТ

Аргачлалд дурдагдаж буй нэр томъёоны тайлбаруудыг холбогдох байгууллагын гаргаснаар болон хуулийн хүрээнд тодорхойлсны дагуу хавсралтаар оруулсан бөгөөд энэхүү хэсэгт ерөнхий ойлголтуудын мэдээллийг хүргэж байна.

### Жендэрийн эрх тэгш байдлын талаарх ерөнхий ойлголт

**Жендэр (Gender)** Жендэрийн эрх тэгш байдал нь орчин үеийн нийгмийн хөгжил, хүний эрхийг дээдлэх үндсэн зарчим бөгөөд хүн бүрийн тэгш оролцоо, боломжийг хангахыг зорьдог. Энэ нь зөвхөн эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондын ялгааг арилгах тухай биш, харин нийгэм дэх аливаа ялгаварлал, гадуурхлыг үгүй хийж, хүйсээс үл хамааран хүн бүрийн чадавхийг бүрэн дүүрэн хөгжүүлэх орчныг бүрдүүлэх буюу тухайн нийгэм, соёлд тогтсон эрэгтэй, эмэгтэй хүний дүр, үүрэг, хүлээлтийн цогц ойлголт юм. Монгол улсын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд зааснаар:

- “жендэр” гэж улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, тэдний нийгэмд эзлэх байр суурийн талаар уламжлагдан тогтсон, түүхэн явцад хувьсан өөрчлөгддөг ойлголт, үзэл, хандлагыг,
- “жендэрийн эрх тэгш байдал” гэж эрэгтэй, эмэгтэй хүн улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцож, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн үр шимээс тэгш хүртэж, хөгжилд эрх тэгш хувь нэмрээ оруулснаар жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байхыг хэлнэ.

Өөрөөр хэлбэл, жендэрийн тэгш байдал (Gender equality) нь эрэгтэй, эмэгтэй хүнд хоёуланд нь ялгаварлалгүй байх үйл явцыг хэлдэг. Хүүхэд бүр сургуульд элсэн суралцах, сурч боловсрох адил тэгш эрхтэй байх ёстой. Жендэрийн тэгш эрх (Gender equity) гэдэг нь онолын хувьд эрэгтэй, эмэгтэй хүмүүст адил тэгш боломж бүхий нөхцөлийг бий болгох юм. Энэ нь хүн бүр хувийн авьяас чадвараа хөгжүүлэх, амьдралдаа сонголт хийхдээ жендэрийн үүрэг болон эмэгтэй, эрэгтэй хүмүүст байх шинж чанарын тухай хэвшмэл ойлголтод баригдахгүй чөлөөтэй байх тухай ойлголт юм. Энэхүү тодорхойлолтоос үзэхэд, жендэр нь зөвхөн биологийн хүйсээр хязгаарлагдахгүйгээр, нийгэм, соёлын хүрээнд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн үүрэг, хариуцлага, байр суурьтай холбоотой ойлголт юм. Эдгээр нь цаг хугацааны явцад өөрчлөгдөж, хувьсан хөгждөг. Жендэрийн эрх тэгш байдал бол зөвхөн хүний эрхийн асуудал төдийгүй эдийн засгийн хөгжил, нийгмийн тогтвортой байдал, иргэдийн амьдралын чанарыг сайжруулах гол хүчин зүйлсийн нэг юм. Гэсэн хэдий ч жендэрийн тэгш бус байдлаас үүдэлтэй нийгмийн болон соёлын тулгамдсан асуудлууд өнөөдөр ч байсаар байна. Сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаа болон боловсролын агуулга нь жендэрийн тэгш бус байдлыг арилгахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

Тиймээс жендэрийн эрх тэгш байдлын тухай ойлголтыг нийгмийн бүх хүрээнд түгээх, ялангуяа боловсролын тогтолцоонд тусгах нь ирээдүйн эерэг өөрчлөлтийг бий болгох үндэс суурь болно. Боловсрол нь тухайн нийгэмд жендэрийн эрх тэгш байдал, тэгш эрхийг бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Тэр дундаа боловсролын салбарын бодлого, эрх зүйн орчин сайжирч, энэ салбар дахь жендэрийн хэвшмэл ойлголтыг халснаар, боловсролын салбарын хөгжилд ихээхэн ахиц дэвшил гарах юм. Бодлого, хууль эрх зүй нь цаашид нийгмийн амьдралын нөхцөл байдал хаашаа эргэхийг тодорхойлж, өөрчлөн шинэчлэх гол арга зам болдог.

### **Бид хэрхэн жендэрждэг вэ?**

Хүн бүр хэд хэдэн ондоошилыг (айдентити, identity) тээж явдаг. Тэдгээрийн зарим нь бидний дотоод мөн чанарт эсвэл заяамал бие махбодод суурилж бүрэлддэг. Заримыг нь гэр бүл, медиа, шашин, итгэл үнэмшил, соёл эсвэл нийгэм тулган хүлээлгэж эсвэл хэлбэржүүлдэг.<sup>11</sup>

Бидний төрмөл хүйсийн ялгаанд оноосон эдгээр “байх ёстой” шинжүүдийг “жендэр” хэмээн нэрийддэг билээ. Биологийн хүйсийн эрэгтэйлэг ба эмэгтэйлэг шинж чанарт тулгуурласан хоёр туйлт нийгмийн үүрэг ба зохих зан үйлийн хүлээлтийг жендэр гэнэ. Эдгээр хүлээлтэд нийцэх үйлдлүүдэд суралцаж буй үйл явцыг “жендэржих” хэмээнэ. Жендэржих үйл явц нь олон талтай. Эцэг эх, асран хамгаалагчид нь охидыг хүүхэлдэйгээр, хөвгүүдийг буу шийдэм, машинаар тоглуулахаас авахуулаад сургууль нь охидод гэрийн ажил хийхийг зааж, хөвгүүдэд мужааны ажил заах нь жендэржүүлэх билээ. Зарим шашны оролцоо ба манлайлал нь эрэгтэйчүүдээр л хязгаарлагдах жишээтэй. Нийгэмд сувилагч, нарийн бичиг, багш зэрэг нь эмэгтэйчүүд байдаг, эмч, менежер, инженер нь эрэгтэйчүүд байдаг гэж ажил мэргэжлийг ч хүйсэд хамаатуулан хэвшмэлээр тодорхойлох нь жендэржүүлж буй тод томруун жишээ юм.<sup>12</sup>

Жендэр нь ялгааны категорчлол төдий бус, бас эрх мэдлийн агуулгатай юм. Энэ ялгаануудыг үнэ цэнээр нь эрэмбэлж зиндаачилдаг эрх мэдлийн тогтолцоо юм. Тухайлбал эрэгтэйлэг шинж чанарыг эмэгтэйлэгээс илүүд үздэг. Эрэгтэйчүүдтэй холбон тодорхойлдог рационал, оюунлаг, хүч чадалтай зэрэг шинжүүдийг сэтгэл хөдлөлтэй, халамжтай зэрэг эмэгтэйчүүдтэй холбодог шинжүүдээс үнэ цэнтэй гэж үздэг. Үр дүнд нь эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү эрх мэдлийг эрхшээдэг. Энэ нь хувийн хувьсгалын олон харилцаанд илэрдэг. Үүнд хетеросексуал хос ба гэр бүлийн дотоод гэх хувийн харилцаанаас авахуулаад шийдвэр гаргах түвшинд буюу улс төрд ч хамаарна. Эрэгтэйчүүд илүү рационал гэх ойлголт хэвшмэл тул шийдвэр гаргах үүрэг тэдэнд оногддог. Харин эмэгтэйчүүд хүлцэнгүй, дуулгавартай байх ёстой учир үзэл бодлыг нь хорьж, үгээ хэлвэл гэсгээж шийтгэх нь байдаг л зүйл билээ.

Эрх мэдлийг эрэгтэйчүүдэд оноон өгдөг нийгмийн тогтолцоог эцгийн эрхт ёс хэмээнэ. Энгийнээр тодорхойлвол “patriarchy” гэдэг нь “эцгийн эрх мэдэл” гэсэн

11 Feminist legal theory and practice, Training manual

12 Bhasin, K. and Khan, N.S. (1986). Some Questions on Feminism and Its Relevance in South Asia, Kali for Women: New Delhi

үг юм. Эмэгтэй хүн бүр эцгийн эрхт ёсны соёлын нөлөөгөөр жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалтад өртсөөр ирсэн ч эмэгтэй бүрийн амссан дарангуйлал харилцан адилгүй, олон хэлбэртэй байдаг. Үндэстэн, угсаатны гарвал, шашин, анги, хөгжлийн ялгаатай байдал ба бэлгийн чиг баримжаа ба хүйсийн баримжаа, хүйсийн илэрхийлэл зэрэг ялгаатай хэдий ч огтлолцох нь элбэг шинжүүдийн нөлөөн дор эмэгтэйчүүдийн ялгаатай туршлагауд бүрэлддэг. Тухайлбал хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хүн хөгжлийн бэрхшээл ба эмэгтэй гэдэг хоёр шинжийн огтлолцол дээр бусад эмэгтэйчүүд болон хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэйчүүдээс ялгаатай онцлог нөхцөл байдалд орших бөгөөд хэд хэдэн янзын давхар ялгаварлалтай нүүр тулах магадлалтай юм.

### **Феминизм гэж юу вэ?**

Феминизмийг олон янзаар тодорхойлдог. Утга нь цаг хугацаа, газар орноос хамааран хувирч байдаг. Тэр ч байтугай хувь хүн бүр туршлага, айдентитигаасаа хамааран өөрийнхөөрөө тодорхойлох боломжтой. Феминизмын тодорхойлолтыг нэг мөр болгоход тулгарч буй нэг бэрхшээл бол үзэл баримтлалын болоод онолын томъёоллыг нь бүх цаг үед үнэн гэж үздэг нэг эх сурвалжаас гаргаж авдаггүй явдал юм.<sup>13</sup> Харин феминизмийг хувьсан өөрчлөгддөг ойлголт гэж хүлээн авах нь хамгийн оновчтой юм. Тухайн өгөгдсөн цаг хугацаа болоод газар орон дахь эмэгтэйчүүдийн соёл, нийгэм, улс төрийн нөхцөл байдал нь феминизмын хүрээг тодорхойлдог.

Хэдий нарийн төвөгтэй, олон талтай хэдий ч феминист үзлийн анхдагч суурь нөхцөл нь эмэгтэйчүүд эмэгтэй учраас дарангуйлагддаг гэх бодит байдал юм. Эмэгтэйчүүдийн нийгэм-эдийн засгийн гарал, арьсны өнгө, үндэс угсаа, нас зэрэг онцлог шинж чанараасаа шалтгаалан өртөх дарангуйллынх нь хэр хэмжээ, буулга нь ялгаатай хэдий ч эмэгтэй хүн гэдгээрээ үргэлж эрчүүдтэй эрх мэдлийн тэгш бус харьцаанд байж, жендэрт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтад өртөмтгий байдаг. Гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн хүчин, бэлгийн дарамт, хөлс багатай хөдөлмөр болон амьдралын бүхий л хүрээнд нь учрах ялгаварлан гадуурхалт зэрэг нь хаа газрын эмэгтэйчүүдэд түгээмэл тохиолддог билээ. Эцгийн эрхт ёсны тогтолцоо эмэгтэйчүүдийн үг үйлдлийн хязгаарыг тогтоож, улс төр, нийгэм, соёлын институциудад нэвтрэн тэдгээрээр дамжуулан эмэгтэйчүүдийн хоёрдогч байр суурийг зүй ёсны хэмээн хүлээн зөвшөөрүүлж улмаар байгалиас заяасан мэт хэвийн гэж итгэж үнэмшүүлдэг.<sup>14</sup>

<sup>13</sup> Bhasin, K. and Khan, N.S. (1986). Some Questions on Feminism and Its Relevance in South Asia, Kali for Women: New Delhi

<sup>14</sup> Feminist legal theory and practice, Training manual

## ХОЁРДУГААР ХЭСЭГ: СУРАХ БИЧГИЙГ ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ БОЛОВСРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Жендэрийн мэдрэмжтэй сурах бичиг нь сургалтын үйл ажиллагаанд сурагч бүр адил тэгшээр оролцох боломжийг бүрдүүлсэн, суралцагчийн нийтлэг онцлог, хэрэгцээний ялгаатай байдлыг харгалзсан, сургалтын үр дүнд сурагч бүрд ахиц дэвшил гаргахад чиглэсэн, жендэрийн тэгш эрхийг эрхэмлэсэн хандлагыг төлөвшүүлэхээр зорьсон, жендэрийн ялгаварлал, дарамт үгүй хэлбэрээр сургалтыг зохион байгуулах стратеги юм.

Энэхүү аргачлал нь сурах бичгийн агуулгыг жендэрийн хэвшмэл ойлголтоос ангид байлгахаар зорин ажиллаж буй сурах бичиг зохиогч, редактор, эрдэмтэн багш нарт удирдамж болох бөгөөд сурах бичгийн агуулгыг жендэрийн тэгш байдлыг хангах олон улсын жишигт нийцүүлэхэд чиглэнэ. Сурах бичиг гэдэгт суралцахуйн хэрэглэгдэхүүн болж буй ЕБС-ын сурах бичиг, гарын авлага, тараах материал, видео болон аудио бичлэг, зурагт хуудас, лабораторын хэрэгсэл зэргийг багтаан ойлгоно.

### СУРАХ БИЧИГ БОЛОВСРУУЛЖ БУЙ МЭРГЭЖИЛТНИЙ БАРИМТЛАХ ЗАРЧИМ<sup>15</sup>

Хүн бүрт нийгэм, соёлын (patriarchy) нөлөөнөөс үүдэлтэйгээр тогтсон өрөөсгөл хандлага (prejudice) буюу ухамсаргүйгээр алагчлах үзэл (unconscious bias) тодорхой хэмжээнд бүрэлдсэн байдаг. Энэ нь бидний үг, үйлдэлд далд байдлаар илэрч аливаа шийдвэр гаргалт, хийж буй ажил, сонголт, хоорондын харилцаанд нөлөөлөх боломжтой. Иймд сурах бичигт жендэрийн тэгш байдлын агуулга тусгахдаа дараах асуултыг асууж, боловсруулах үйл явцад анхаарч ажиллахыг хичээх хэрэгтэй.

- 1. Тэгш байдлыг хүндэтгэх:** Та сурах бичгийн агуулга боловсруулахдаа санамсаргүйгээр аль нэг хүйсийг илүүд үзэх, хөгжлийн бэрхшээл, нас, ажил мэргэжил, үндэс угсаагаар ялгаварлан гадуурхах хандлага гаргасан байх боломжтой юу? Агуулгад ашигласан аливаа жишээ, зураг, өгөгдөлд эрх тэгш байдлыг эрхэмлээрэй.
- 2. Хэвшмэл ойлголтыг арилгах:** Та нийгэмд тогтсон хэвшмэл ойлголтыг бататгаж, шинэ тутам мэдээ мэдээлэл, жишээ ашиглахгүйгээр хэвшмэл сөрөг ойлголтуудыг өөгшүүлсэн байх магадлалтай юу? Аливаа мэргэжил, үүрэг хариуцлага, чадвар зэргийг хэвшмэл байдлаар дүрслэхгүй байхад анхаараарай.
- 3. Олон талт байдалд анхаарах:** Таны хувьд олон талт байдал гэдэгт юуг ойлгох вэ? Нийгмийн олон талт байдал, тэр дундаа хүйсийн болон бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэл, шашин шүтлэг, хэл, соёл, амьдралын хэвшил, орлогын ялгаатай байдал, үндэс

угсаа, хөгжлийн ялгаатай байдал зэргийг хүлээн зөвшөөрч, бүх суралцагч өөрийнхөөрөө байх боломжийг олгоорой.

4. **Эерэг дүр төрхийг дэмжих:** Таны бэлтгэсэн агуулга хэт албаны эсвэл ямар нэг сөрөг сэтгэгдэл төрүүлэхүйц мэдээллийг багтаасан байх эрсдэлтэй эсэхэд анхаарна уу. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хүч чадал, авьяас чадвар, амжилт, хувь нэмрийг эерэг байдлаар харуулж, сурагчдад үлгэр дууриал болохуйц байдлаар тусгаж, мөн хүчирхийлэл, дарамт харуулахаас татгалзаарай.
5. **Бодитой агуулгыг тусгах:** Та жендэрийн агуулгыг тусгахдаа хэн нэгний нэг талыг баримталсан дүгнэлт эш татсан байх боломжтой юу? Жендэрийн талаарх мэдээлэл, жишээг шинжлэх ухааны үндэслэлтэй, бодитой байдлаар боловсруулах, хэт нэг талыг баримталсан дүгнэлт хийхээс болгоомжлоорой.

#### **СУРАХ БИЧГИЙГ ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ БОЛОВСРУУЛАХ АРГАЧЛАЛ<sup>16</sup>**

Зохиогчид санаатай болон санамсаргүйгээр сурах бичиг болон бусад сургалтын хэрэглэгдэхүүнд жендэрийн хэвшмэл үзэл агуулсан эх, зураг, дүрслэлийг оруулах тохиолдол цөөнгүй байдаг. Энэ нь ирээдүйд, хойч үеийнхэнд хэвшмэл ойлголтыг уламжлуулах, түгээх эрсдэлийг дагуулдаг. Иймд сурах бичиг болон сургалтын хэрэглэгдэхүүнийг боловсруулахдаа агуулгын талаарх үндсэн шаардлагыг мөрдөхийн зэрэгцээ зураг, эхийн агуулга, бүтэц нь тодорхой шаардлагуудыг хангах нь зүйтэй.

##### **АГУУЛГАД ТАВИГДАХ ҮНДСЭН ШААРДЛАГА**

###### **Жендэрийн тэгш байдлыг хангасан агуулга**

- Бүх сурагчдад тэгш хүртээмжтэй, ойлгомжтой байх
- Агуулгад жендэрийн хэвшмэл ойлголт, ямар нэг байдлаар ялгаварлан гадуурхах үзэл, хүйсээр, орлогын болон хөгжлийн ялгаатай байдлаар ялгаварлах хандлагыг тусгахгүй байх
- Хүн бүрийн нийгэмд гүйцэтгэх үүрэг, байр суурь, хариуцлагыг адил үнэлэх, тусгах

###### **Хэвшмэл ойлголтыг шүүмжлэх агуулга**

- Жендэрийн тэгш бус байдлын сөрөг нөлөөг тодорхойлсон бодит жишээ, тохиолдлыг агуулгад багтаах
- Сурагчдад жендэрийн хэвшмэл ойлголтыг таньж, шүүмжлэн дүгнэх боломж олгох
- Жендэрийн хэвшмэл хандлага, уламжлалт ойлголтуудыг задлан шинжлэхэд дэмжлэг үзүүлэх

###### **Олон төрлийн дүр, жишээг багтаах**

- Агуулгад янз бүрийн мэргэжил, зүс царай, нас хүйс, ажил үүргийн ялгаатай дүрүүдийг тэнцвэртэй тусгах
- Олон янзат байдлыг харуулсан үндэс угсаа, ялгаатай бэлгийн чиг баримжаатай хүмүүсийн түүх, амьдралын туршлагыг тэнцвэртэй харуулах

<sup>16</sup> Боловсрол дахь жендэрийн тэгш байдлын гарын авлага (2017), ЮНЕСКО

## ЗУРАГ, ЭХИЙН АГУУЛГА, БҮТЦЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

### Зурагт тавигдах шаардлага

- Зурагт дүрслэгдэж буй дүрүүдийн ажил үүргийн хуваарилалт, хувцаслалт, биеийн хэлбэр, цариа төрхөд жендэрийн хэвшмэл ойлголтыг шингээхгүй байх
- Хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон, өнгөлөг, гэгээлэг, хүчирхийлэл агуулаагүй зураг ашиглах

### Эхийн агуулга, бүтэц

- Эх бүр тодорхой зорилготой, жендэрийн мэдрэмжтэй хандлагыг дэмжсэн байх
- Эхийн доторх дүрүүд, тэдний хоорондын харилцаа, өгүүлэмж жендэрийн эрх тэгш байдлыг тусгасан байх
- Эхийн бүтэц логиктой, хялбар ойлгогдохуйц байх

### 3. Тест, дасгал ажилд тавигдах шаардлага

- Хүйсээс үл хамааран бүх сурагчдад ижил сорилт, чадварыг шалгах боломжийг олгох.
- Жендэрийн хэвшмэл ойлголтыг таних, шүүмжлэх, шийдвэрлэх чадварыг хөгжүүлэх асуултаудыг оруулах.

## Сурах бичиг боловсруулах үе шатанд жендэрийн мэдрэмжийг хангах

### 1. Анализ:

- Одоо хэрэглэж буй сурах бичгийн жендэрийн хандлагыг шинжлэх.
- Жендэрийн хэвшмэл ойлголт агуулсан хэсгүүдийг илрүүлэх.

### 2. Төлөвлөлт:

- Жендэрийн мэдрэмжтэй байлгахын тулд агуулга, бүтэц, дасгал ажлуудаа тодорхойлох.
- Агуулгад эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн үүрэг тэнцвэртэй тусгагдсан эсэхийг шалгах.

### 3. Шалгуур үнэлгээ:

- Боловсруулсан сурах бичгийг жендэрийн эрх тэгш байдлын үүднээс хөндлөнгийн мэргэжилтнүүдээр үнэлүүлэх.

### 4. Хяналт, шинжилгээ:

- Хэрэгжүүлсний дараа сурах бичгийн хэрэглээ, сурагчдын жендэрийн талаарх ойлголтын өөрчлөлтийг хянах.

**СУРАХ БИЧГИЙГ ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙГЭЭР БОЛОВСРУУЛАХАД ТУСЛАХ ПРАКТИК АРГАЧЛАЛУУД**

№	Аргачлал	Зөвлөмж	Жишээ
1	Жендийн мэдрэмжтэй текст бичих	<ul style="list-style-type: none"> <li>• Хүйсийн ялгаварлалгүй, төвийг сахисан үг хэллэг хэрэглэх:</li> <li>• Жишээ болон кейс бичихдээ хүйсийн хэвшмэл ойлголтоос зайлсхийж, аливаа мэргэжил, үйлдлийг эрэгтэй, эмэгтэй аль аль нь хийх боломжтойг тусгах</li> <li>• Бодит амьдрал дээрх олон талт байдлыг харуулсан жишээ ашиглах:</li> <li>• Тодорхой нас, угсаатан, шашин, тодорхой бүлгийн төлөөлөл хүмүүсийг дорд үзсэн үг, хэлц үг, нэр томъёог, тэмдэг нэр ашиглах ёсгүй.</li> <li>• Сурах арга барилын ялгааг тусгасан олон хэлбэр бүхий даалгав боловсруулах</li> </ul>	<p><i>Охид” эсвэл “хөвгүүд” гэж онцгойлон хүйс заасан үгсээс зайлсхийх. Сурагчид, хүүхэд бүр гэх мэт ерөнхий үг ашиглах</i></p> <p><i>Эмэгтэйчүүд хоол хийх, гэр цэвэрлэх, асрахуйн ажил хөдөлмөр эрхэлдэг гэх мэт хэвшмэл ойлголтоос татгалзаж, оронд нь “Хүн бүр гэрийн ажилд оролцдог” гэх зэргээр найруулан бичих</i></p>
2	Жендэрийн тэгш байдлыг харуулсан дүрслэл ашиглах	<ul style="list-style-type: none"> <li>• Зураг, графикт эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн оролцоог тэнцвэртэй тусгах</li> <li>• Дүрслэлд жендэрийн хэвшмэл ойлголтоос ангид байдлыг харуулах</li> <li>• Сурагчдын нас, хүйсээс үл хамааран ойлгохуйц, дүрслэл оруулах.</li> <li>• Сурах бичгийн зургуудад эрэгтэй, эмэгтэй дүрүүдийг тэнцвэртэй харуулах, аль аль нь идэвхтэй, бүтээлч байдлаар дүрслэгдэх</li> <li>• Олон төрлийн мэргэжлийг харуулах, жишээ нь эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн оролцоог уламжлалт бус салбарт харуулах. Эмэгтэйчүүдийг инженер, барилгачин, эрэгтэйчүүдийг балетчин, сувилагч байдлаар дүрслэх</li> <li>• Ялгаварлалгүй орчинг сурталчлах, сурагчид хүйсээс үл хамааран хамтран ажиллаж буй байдлаар зурагт дүрслэгдсэн байх.</li> </ul>	<p><i>Спортын жишээ дурдахдаа эрэгтэй, эмэгтэй тамирчдын ижил тэнцүү оролцоо, амжилтыг харуулах</i></p> <p><i>Сурах бичгийн зурагнуудыг эрэгтэй, эмэгтэй, ахмад настан, хөгжлийн ялгаатай байдал, төрөл бүрийн ажил мэргэжил, нийгмийн оролцоотойгоор харуулах</i></p> <p><i>Эмэгтэй инженер эсвэл эрэгтэй багшийн дүрслэл оруулах.</i></p> <p><i>Эцэг, эх, асран хамгаалагчид хүүхдүүдийн хамт хоол хийх эсвэл спортод оролцож байгаа дүрслэл ашиглах</i></p>

		<ul style="list-style-type: none"> <li>• Эрэгтэй, эмэгтэй хүнийг хэвшмэл үзэл, өрөөсгөл хандлагаар дүрслэн харуулаагүй байх</li> <li>• Эрэгтэй, эмэгтэй хүний дүр-үүрэг, сэтгэл хөдлөл, талбар, эрх мэдлийн харилцааны уламжлалт дүр төрхийг эергээр өөрчлөх. Түүхэн баримт, уран зохиолын эх ашиглах тохиолдолд жендэрийн талаас шүүмжлэлтэй нүдээр үнэлж дүгнэх асуулт даалгавар бүхий байх</li> <li>• Жендэрийн хувьд ялгаж онцгойлсон буюу зөвхөн нэг хүйсийн баатрууды дөвийлгөн илэрхийлэхгүй байх (эрдэмтэд, зохиолчид, баатрууд, спорт урлагийн оддын тухай оруулахдаа хэнийг гол төлөв онцолсон байна вэ?)</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Хэнийг олонтоо дүрслэн оруулсан байна вэ? Дүрслэхдээ ямар байршилд харуулсан байна вэ?</li> <li>• эрэгтэй, эмэгтэй хүнийг ямар дүрээр, ямар тэмдэг нэр хэрэглэн, ямар үйл хийж байгаагаар дүрсэлсэн байна вэ?</li> </ul>
3	<p>Жендэрийн тэгш байдлыг хангасан кейс, жишээ ашиглах</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Мэргэжил, үүрэг хариуцлагыг жендэрээр хязгаарлахгүйгээр бүх хүйсийн жишээ оруулах</li> <li>• Эерэг үлгэр дуурайлал харуулах, сурагчдад жендэрийн хэвшмэл ойлголтыг халсан, амжилттай эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн жишээг харуулах. Эрэгтэй багш, эмэгтэй эрдэмтэн, удирдагчийн түүх гэх мэт.</li> <li>• Олон талт байдлыг харуулах. Үндэстэн, соёлын олон янз байдлыг харуулсан кейс ашиглан жендэрийн хэвшмэл үзлийг арилгах</li> <li>• Мэргэжлийн тэгш байдал, Охид, хөвгүүдэд мэргэжлээ хүйсээс үл хамааран сонгох боломжтойг харуулсан кейс ашиглах.</li> </ul>	<p>Жишээ нь хими, физикийн хичээлд эрэгтэй, эмэгтэй аль аль нь туршилт хийхэд оролцож байгаа жишээг ашиглах</p> <p><i>Хүн бүр STEM салбарт ажиллаж чадна. Сурагч бүр багш болох боломжтой гэх мэт</i></p> <p><i>Өөр өөр хүйс, нас, үндэс угсаатай хүмүүсийн жишээг сонгож, сурагчдыг олон талт байдлыг хүндэтгэхэд сургах</i></p>

4	<p>Сурах бичгийн хэл найруулгад жендэрийн мэдрэмжийг тусгах</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хувь нэмэр, амжилтыг ижил хэмжээнд онцлох</li> <li>• Бэлгийн цөөнхийн талаарх мэдээллийг тусгах</li> <li>• Төвийг сахисан хэл найруулга</li> </ul>	<p>Текстэнд эрэгтэй, эмэгтэй гэхээс илүү “хүн, сурагч, хүүхэд” гэж бичих</p> <p><i>Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн үүрэг оролцоог харилцан адилгүйгээр хэт нэг талыг баримталсан хандлагаас зайлсхийх, жишээ нь түүхэн дүр, улс төрийн зүтгэлтэн зэргийг сонгохдоо аль нэг хүйс давамгайл харуулахаас зайлсхийх</i></p>
5	<p>Хяналт, үнэлгээний систем нэвтрүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Сурах бичгийн агуулгад жендэрийн тэгш байдлыг хангах шалгуур үзүүлэлт боловсруулж тогтмол хянах</li> <li>• Хэвлэгдсэн сурах бичгүүдэд багш, сурагчид болон хөндлөнгийн судлаач, активистын санал, үнэлгээг авч тогтмол сайжруулалт хийх</li> <li>• Агуулга, дүрслэлд жендэрийн хэвшмэл ойлголт байгаа эсэхийг шалгах, хянах, анзаарах</li> </ul>	<p><i>Сурах бичгийн агуулгад жендэрийн ялгаварлал байгаа эсэхийг үнэлэх, үнэлгээний хуудас боловсруулах</i></p>
6	<p>Багш нарт зориулсан заах арга зүй</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Багш нарт жендэрийн мэдрэмжтэйгээр сурагчидтай харилцах сургалтыг тогтмол зохион байгуулах.</li> <li>• Хичээл заахдаа охид, хөвгүүдийн оролцоог тэнцвэртэй байлгахад анхаарах</li> <li>• Даалгавар, асуултаа хүйсээс үл хамааран тэгш хуваарилах.</li> <li>• Сурах бичгийн агуулгад жендэрийн агуулга туссан эсэхийг шалгах хяналтын механизм боловсруулж, тогтмол хянах.</li> <li>• Сурагчид, багш нар, эцэг эхчүүдийн оролцоотойгоор сурах бичгийн агуулгыг үнэлэх.</li> <li>• Охид, хөвгүүдийг хичээлийн хэлэлцүүлэг, багийн ажилд хамтран оролцуулах.</li> <li>• Эерэг урамшуулал бий болгох, Хүйсээс үл хамааран сурагчдыг авьяас чадвараа хөгжүүлэхэд урамшуулах.</li> </ul>	<p><i>Хичээл дээр охид, хөвгүүдийг хамтарч ажиллах, тэдний санал бодлыг чөлөөтэй илэрхийлэх нөхцөлийг бүрдүүлэх.</i></p>

7	Жендэрийн талаарх мэдээлэл багтаах	<ul style="list-style-type: none"> <li>Жендэрийн мэдрэмжийг таниулах хичээл: Хүний эрх, жендэрийн эрх тэгш байдлын ач холбогдлыг хүүхдэд ойлгуулах.</li> <li>Бодит түүх, жишээ: Жендэрийн эрхийн төлөө тэмцсэн дэлхий дахины жишээ болон Монголын сайн туршлагуудыг хуваалцах.</li> </ul>	<p>Сурагчид жендэрийн тэгш байдлын ач холбогдлыг ойлгоход туслах агуулга нэмж оруулах.</p> <p>Жендэрийн тэгш байдалд чиглэсэн дэлхийн болон Монголын сайн туршлагыг хуваалцаж, урам зориг өгөх.</p>
---	------------------------------------	---	---

## ҮНДСЭН ЧИГЛЭЛ

<p><b>Жендэрийн мэдрэмжтэй агуулгыг тодорхойлох</b></p> <p>Хүүхдүүдийн өдөр тутмын амьдралд ойр, тэдэнд үлгэр дуурайл үзүүлэхүйц, жендэрийн хэвшмэл ойлголтыг халсан жишээ, кейс, дүрслэлийг сурах бичигт тусгах</p>	<p><b>Жендэрийн тэгш байдлыг дэмжих дүрслэл, хэллэг хэрэглэх</b></p> <p>Агуулгад эрэгтэй, эмэгтэй, хөгжлийн бэрхшээлтэй болон бусад олон талт байдлыг эрх тэгш байдлаар тусгах. Үүнд дүрслэл, зураг, текстэд жендэрийн ялгаваргүй байдлыг харуулах</p>
<p><b>Хүйсээс хамаарах ялгаварлалгүй агуулга төлөвлөх</b></p> <p>Мэргэжил, үүрэг хариуцлага, нийгмийн оролцоог хүйсийн хэвшмэл ойлголтоор бус, бодит байдал, олон талт боломжийг тусгасан байдлаар танилцуулах.</p>	<p><b>Багш нар болон зохиогчдод зориулсан удирдамж боловсруулах</b></p> <p>Жендэрийн мэдрэмжтэй агуулга боловсруулж, сурагчдад зөв мэдээлэл дамжуулахад туслах арга зүйг багш, зохиогчдод зааварлах.</p>
<p><b>Хяналт, үнэлгээний механизм бүрдүүлэх</b></p> <p>Сурах бичгийн агуулга жендэрийн мэдрэмжтэй болсон эсэхийг тогтмол хянах, үнэлэх, сайжруулах боломжийг бүрдүүлэх.</p>	

Сурах бичгийн агуулга нь жендэрийн хэвшмэл ойлголтыг бататгасан, эсвэл дам байдлаар дэмжсэн эсэхийг нягталж өөрчлөлт хийхээр зорих ёстой. Бүх хичээлүүдэд жендэрийн хэвшмэл ойлголт, өрөөсгөл хандлагыг өөрчлөхөд чиглэсэн агуулга бүхий төрөл бүрийн эх сурвалж ашиглах замаар агуулгын интеграци хийх боломжтой. Мөн бүх хичээлийн агуулгыг жендэрийн мэдрэмжтэй боловсруулах боломжтой бөгөөд уран зохиол болон математикийн хичээлийг жишээ болгон боловсруулав.

### Уран зохиолын хичээлд жендэрийн эрх тэгш байдлын агуулга тусгах нь:

Уран зохиолын хичээлийн хүрээнд *жендэрийн хэвшмэл ойлголт бүхий зохиол уншсан хэдий ч жендэрийн линзээр харсан шүүмж бичих, дүн шинжилгээ хийх замаар жендэрийн эрх тэгш байдлыг агуулгыг тусгах боломжтой*. Үүний зэрэгцээ хэвшмэл ойлголтын асуудлыг хөндсөн, өөрчилсөн зохиолын жагсаалт үүсгэж, анги тус бүрийн уран зохиолын хичээлд оруулах шаардлагатай.

## ◆ Уран зохиолын хичээлд жендэрийн эрх тэгш байдлыг тусгах ЖИШИГ АРГАЧЛАЛ

### Хичээлийн зорилго

- Уран зохиолын агуулгад жендэрийн эрх тэгш байдлыг хэрхэн тусгах тухай ойлголт өгөх
- Хичээлийн агуулгыг жендэрийн мэдрэмжтэй болгох арга замыг тодорхойлох
- Жендэрийн эрх тэгш байдлыг сурган хүмүүжүүлэхэд уялдуулах бүтээлч арга барилыг хөгжүүлэх

### 1. ЕБС-ийн уран зохиолын хичээл дахь жендэрийн үзэл баримтлал

- **Жендэрийн эрх тэгш байдлын зорилго:** Уран зохиолоор дамжуулан сурагчдад хүйсээс үл хамааран ялгаагүйгээр тэгш боломж, хүндэтгэлийг ойлгуулж, бодит амьдралд хэрэгжүүлэх ур чадвар олгох.
- **Шаардлага:** Сурах бичигт жендэрийн хэвшмэл ойлголтыг өөгшүүлэх, ялгаварлан гадуурхах байдал, жендэрийн тэгш бус байдлыг тусгахаас зайлсхийх.

### 2. Дасгал ажил

#### А. Өгөгдсөн зохиолын агуулгыг жендэрийн линзээр харж, дүн шинжилгээ хийх дасгал

##### 1. Зохиолын дүрүүдийг задлан шинжлэх:

- Зохиолд дүрслэгдсэн эрэгтэй, эмэгтэй дүрүүдийн хэн нь гол дүр болж дүрслэгдсэн байна вэ?
- Зохиолд гарч буй дүрүүдийн хийж буй үйлдлүүд ялгаатай байна уу? Яагаад өөр байна вэ?
- Зохиолд жендэрийн хэвшмэл ойлголт байна уу? Хэрэв байна гэж үзвэл, чи аль хэсгийг хэвшмэл ойлголт гэж тодорхойлж байна вэ? Яагаад гэдгийг ангийнхантайгаа ярилцаарай.

##### 2. Дүн шинжилгээний асуултауд:

- Дүрүүдийн хоорондын харилцаа эрх тэгш байна уу? Тэдний хооронд эрх мэдэл, үүрэг хариуцлагын ялгаа байна уу?
- Эрэгтэй, эмэгтэй дүрүүдийн талаарх үнэлэмж, үг хэллэг, үйлдэл хэрхэн илэрхийлэгдсэн байна вэ?
- Хэрэв дүрүүдийн хүйсийг сольвол үйл явдалд хэрхэн нөлөөлөх вэ? Яаж өрнөх бол?

## Б. Дүрд тулгуурласан бичгийн дасгал

### 1. Зохиолын аль нэг дүрийг сонгоод дараах асуултад хариулаарай.

- Энэ дүрийн амьдрал, үзэл бодол нь жендэрийн ялгаварлан гадуурхалтгүй нийгэмд ямар байж, хэрхэн өрнөх байсан бэ?
- Тус дүр төрсөн хүйсээсээ, эсвэл ялгаатай байдлаасаа хамаарч эрх нь зөрчигдөж, ямар нэг боломжийг алдсан эсэхийг тодорхойлоорой.
- Дүрийн гүйцэтгэж буй үүргийг жендэрийн мэдрэмжтэйгээр хувирган зохиолыг өөрчилж бичээрэй. Жишээ нь зохиолд гарч байгаа гол дүрийг эсрэг хүйстнээр нь эсвэл хөгжлийн бэрхшээлтэй хүний дүрээр сольж үүсэх үйл явдлын өөрчлөлтийг төсөөлж бичээрэй.

### Бүтээлч ажил:

### 2. Сонгосон зохиолын нэг хэсгийг жендэрийн тэгш байдлын үүднээс шинэчилж бичих эсвэл дүрд тоглож харуулах

### 3. Зохиолыг өөр өнцгөөс уншиж, жендэрийн тэгш байдалд нийцсэн шийдлийг тодорхойлох

### 3. Сурах бичигт тусгах жендэрийн мэдрэмжтэй арга зүй ашиглах нь Зохиол сонгох үе шатанд:

- Уран зохиолын дүрүүд болон үйл явдал жендэрийн хэвшмэл ойлголтийг өөгшүүлээгүй, бүх сурагчдад нээлттэй утга санааг илэрхийлж байгаа эсэхийг шалгах.
- Хүйсийн эрх тэгш байдлыг харуулсан эсвэл тогтсон сөрөг ойлголтыг сөрсөн, хүчирхийлэл дарамтгүй зохиолуудыг сонгох.
- Зөвхөн эрэгтэй го дүрүүд л гардаг зохиол сонгохоос зайлсхийх.

Жендэрийн мэдрэмжтэй зохиол сонгохдоо хүйсийн хэвшмэл ойлголтод шүүмжлэлтэй хандсан эсэхийг анзаарч, олон янзат соёл, нийгмийн хандлагыг сурагчдад ойлгуулахуйц зохиол байвал давуу талтай.

### Агуулга боловсруулахдаа:

- Дүрүүдийн үйл хөдлөл, зан чанар, нийгмийн үүргийг хүйсээс үл хамааран шинжлэх.
- Жендэрийн хэвшмэл ойлголт, ялгаварлан гадуурхлыг шүүмжлэн дүгнэх асуулт, даалгаврыг оруулах.

### Жендэрийн дүн шинжилгээ ба Ш.Гаадамба, “Элбэг дээл”<sup>17</sup> зохиол

“Элбэг дээл” зохиол нь Монголын ардын ахуй амьдрал, хүний сэтгэл зүй, нийгмийн харилцааг бодитой тусгасан өгүүллэг юм. Энэхүү зохиол нь тухайн үеийн нийгмийн

<sup>17</sup> [https://library.to.gov.mn/epub\\_post\\_type/%D1%8D%D0%BB%D0%B1%D1%8D%D0%B3-%D0%B4%D1%8D%D1%8D%D0%BB/#epubcfi\(/6/6\[id23\]!/4/2/1:0\)](https://library.to.gov.mn/epub_post_type/%D1%8D%D0%BB%D0%B1%D1%8D%D0%B3-%D0%B4%D1%8D%D1%8D%D0%BB/#epubcfi(/6/6[id23]!/4/2/1:0)

хүйсийн ялгаатай байдал, жендэрийн хэвшмэл ойлголт, үүрэг хариуцлагыг тодорхой хэмжээгээр тусгасан. Эрэгтэй, эмэгтэй дүрүүдийн үйлдэл, харилцаа, нийгэмд гүйцэтгэх үүрэг нь тухайн үеийн уламжлалт, жендэрийн хэвшмэл ойлголтын тусгал болжээ. Жендэрийн дүн шинжилгээ хийхдээ зохиолын агуулга, дүрүүдийн амьдралын боломж, нийгмийн харилцаанд нөлөөлж буй хүчин зүйлүүдийг жендэрийн линзээр харж хэвшмэл ойлголтыг таньж, шүүмжлэх боломжийг олгоход чиглүүлэг болох нь чухал билээ. Шанжмятавын Гаадамбын “Элбэг дээл” зохиолыг ашиглан жендэрийн мэдрэмжтэй уран зохиолын хичээлийн агуулга боловсруулах төлөвлөгөөг харуулав.

## 1. ХИЧЭЭЛИЙН ЗОРИЛГО:

- “Элбэг дээл” зохиолын агуулга, дүрүүдийн жендэрийн үүрэг, харилцааг ойлгож, дүн шинжилгээ хийх.
- Зохиолд агуулагдаж буй жендэрийн хэвшмэл ойлголт, тэгш бус байдлыг илрүүлж, тэдгээрийг хэрхэн даван туулах талаар сурагчдын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх

## 2. ХИЧЭЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ:

Хичээлийн цаг: 2 хичээлийн цаг (80 минут) Үе шат:

### 1. Удиртгал (10 минут):

- Зохиолч Ш.Гаадамбын намтар, уран бүтээлийн товч танилцуулга
- “Элбэг дээл” зохиолын товч агуулга, гол дүрүүдийн танилцуулга
- Жендэрийн эрх тэгш байдлын үндсэн ойлголтыг танилцуулж, сурагчдын өмнөх мэдлэгийг тодруулах.

### 2. Үндсэн хэсэг (60 минут):

- Зохиолын уншлага ба хэлэлцүүлэг (30 минут):  
Зохиолын тодорхой хэсгүүдийг сурагчдаар уншуулж, гол үйл явдлуудыг ярилцах, дүрүүдийн жендэрийн үүрэг, харилцааг тодорхойлох асуулт, хариулт явуулах
- Дасгал ажил (30 минут): Асуулт хариулт:
  - Зохиолын гол дүрүүдийн үүрэг, үйлдэлд жендэрийн ямар хэвшмэл ойлголт ажиглагдаж байна вэ?
  - Дүрүүдийн хоорондын харилцаанд жендэрийн тэгш бус байдал хэрхэн илэрч байна вэ?
  - Хэрэв зохиолын гол дүрийн хүйсийг өөрчилбөл үйл явдалд ямар өөрчлөлт гарах вэ?

Бүтээлч ажил:

- Сурагчдыг багаараа ажиллуулж, зохиолын нэг хэсгийг жендэрийн тэгш байдлыг харуулсан байдлаар өөрчлөн бичих.

- Өөрчилсөн хэсгээ ангийнхаа өмнө танилцуулж, хэлэлцүүлэг өрнүүлэх.

### 3. Дүгнэлт (10 минут):

- Хэлэлцүүлгээс гарсан дүгнэлтүүдийг нэгтгэж, жендэрийн тэгш байдлын ач холбогдлыг онцлох.
- Сурагчдаас хичээлийн талаархи санал, сэтгэгдлийг сонсож, асуултанд хариулах

### 3. ДАСГАЛ АЖИЛ:

#### А. Асуулт хариулт:

1. Зохиолын аль дүрүүд жендэрийн хэвшмэл ойлголтыг илэрхийлж байна вэ? Жишээ татан тайлбарлаарай.
2. Дүрүүдийн үйлдэл, үүрэгт жендэрийн тэгш бус байдал хэрхэн нөлөөлж байна вэ?
3. Хэрэв зохиолын гол дүрийн хүйсийг эсрэгээр нь сольсон бол үйл явдалд ямар өөрчлөлт гарах байсан бэ?

#### Б. Бүтээлч ажил:

1. Зохиолын нэг хэсгийг сонгон авч, жендэрийн тэгш байдлыг харуулсан байдлаар өөрчлөн бичээрэй.
2. Өөрчилсөн хэсгээ ангийнхаа өмнө танилцуулж, хамтдаа хэлэлцээрэй.

#### 4. Хичээлийн дүн шинжилгээний аргачлал:

- Дүрүүдийн жендэрийн үүрэг, харилцааг шинжлэх:
  - Зохиолын дүрүүдийн үүрэг, үйлдэл, харилцааг жендэрийн өнцгөөс задлан шинжлэх.
  - Жендэрийн хэвшмэл ойлголт, тэгш бус байдлыг илрүүлэх.
- Жендэрийн тэгш байдлыг хангах арга замыг тодорхойлох:
  - Зохиолын агуулгад жендэрийн тэгш байдлыг хэрхэн тусгаж болох талаар сурагчдын санал, санаачилгыг дэмжих.
  - Дүрүүдийн үүрэг, харилцааг жендэрийн тэгш байдлын үүднээс өөрчлөх боломжийг хэлэлцэх.

#### 5. Хүлээгдэж буй үр дүн:

- Сурагчид зохиолын агуулга, дүрүүдийн жендэрийн үүрэг, харилцааг ойлгож, дүн шинжилгээ хийх чадвартай болно.
- Жендэрийн хэвшмэл ойлголт, тэгш бус байдлыг таньж, тэдгээрийг даван туулах арга замыг тодорхойлох чадвар эзэмшинэ.
- Уран зохиолын бүтээлээр дамжуулан жендэрийн тэгш байдлын талаархи мэдлэг, ойлголтоо гүнзгийрүүлнэ.

## МАТЕМАТИКИЙН ХИЧЭЭЛИЙГ ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ АГУУЛГААР БОЛОВСРУУЛАХ ЖИШИГ АРГАЧЛАЛ

### I. Ерөнхий зарчим

#### 1. Хүйсийн хэвшмэл ойлголтыг арилгах

- Хичээлийн жишээ, дасгал, агуулгад хүйсийн ялгаварлал, хэвшмэл ойлголтыг тусгахгүй байх.
- Эмэгтэй, эрэгтэй сурагчдын ижил түвшний чадвар, оролцоог дэмжих.

#### 2. Олон талт байдал ба хүндэтгэл

- Жендэрийн олон янз байдал, нийгмийн үүргийг тэгш тусгах.
- Жишээ болон даалгаварт дүрслэгдэж буй хүмүүсийн үүрэг, үйл ажиллагаа нь жендэрийн мэдрэмжийг агуулсан байх.

#### 3. Сурах орчинд жендэрийн тэгш байдал хангах

- Багшийн хандлага болон үнэлгээнд сурагчдын хүйс нөлөөлөхгүй байх.
- Сурагчдын санал бодлыг тэгш сонсох, бүх сурагчдын оролцоог дэмжих.

### II. Жендэрийн мэдрэмжтэй хичээл боловсруулах үе шат

#### Зорилго

- Сурагчдад жендэрийн тэгш байдлын талаарх ойлголтыг математикийн агуулгад тусган хүргэх. **Жишээ:** Хичээлээр дамжуулан бодлого бодох, мэдээлэл боловсруулах явцад жендэрийн хэвшмэл ойлголтыг шүүмжилж сурах.

#### Агуулга төлөвлөх

- Дасгал, бодлогын жишээнд хүйсийн ялгаварлалыг арилгасан, жендэрийн мэдрэмжтэй дүрслэл, тоон мэдээллийг багтаах. **Жишээ:**
  - Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хөдөлмөрийн бүтээмж, цалингийн мэдээллийг харьцуулж, жендэрийн ялгааг бодлогоор задлан шинжлэх.
  - Хувь хүний орлогын менежмент, санхүүгийн зорилтод жендэрийн нөлөөг тусгасан жишээ боловсруулах.

#### 3. Хичээл заах арга

- Сурагчдыг бодлого бодох явцад жендэрийн тэгш эрхийн талаарх ойлголтыг хөндсөн асуултаар өдөөнө. **Жишээ асуулт:**

- Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн хөдөлмөрийн зах зээл дэх оролцоо тоогоор буюу тоон мэдээллээр хэрхэн илэрч байна вэ?
- Эрэгтэй, эмэгтэй багийн гишүүд ижил түвшинд хувь нэмэр оруулсан төслийн орлогыг хэрхэн хуваах вэ?

#### 4. Үнэлгээ хийх

- Дасгал, бодлогыг бодох явцад сурагчдын жендэрийн мэдрэмжийг нэмэгдүүлсэн байдалд үнэлгээ хийх. Жишээ:
  - Бодлого бодоход зөвхөн тооцоо гүйцэтгэлийг үнэлэхээс гадна, жендэрийн тэгш байдлыг хэрхэн авч үзэж байгааг үнэлэх.

### III. Жишиг дасгал, бодлого

#### Жишээ бодлого: Орлогын харьцуулалт

Нэгэн компани эрэгтэй, эмэгтэй ажилтнууддаа адилхан ажил үүрэг хуваарилаж түүндээ тохирсон цалин олгодог. Эрэгтэй ажилтны нэг сарын цалин 1,200,000₮, эмэгтэй ажилтны цалин 1,000,000₮. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн цалингийн зөрүүг тооцолно уу. Үүнд жендэрийн цалингийн ялгаа байна уу? Хэрэв байвал шалтгаан, шийдвэрлэх арга замыг тооцоол.

#### Жишээ бодлого: Дундаж наслалт

Монгол Улсад сүүлийн судалгаагаар эрэгтэйчүүдийн дундаж наслалт 66, эмэгтэйчүүдийнх 76 жил байна. Дараах асуултаудад хариулж бодлого бодно уу:

1. Монгол Улсын нийт дундаж наслалтыг тооцоол. Үүнд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн харьцаа 1:1 гэж үзнэ.
2. Хэрэв эрэгтэйчүүдийн тоо нийт хүн амын 49%, эмэгтэйчүүдийнх 51% бол нийт дундаж наслалт хэрхэн өөрчлөгдөх вэ?
3. Эрэгтэйчүүдийн дундаж наслалт эмэгтэйчүүдээс 10 жилээр бага байна. Энэ ялгааг багасгахын тулд эрэгтэйчүүдийн дундаж наслалтыг 5 жилээр нэмэгдүүлбэл нийт дундаж наслалт хэд болох вэ?
4. Жендэрийн наслалтын ялгаа ямар хүчин зүйлээс үүдэлтэй байж болохыг хэлэлцэнэ үү. Энэ ялгааг арилгах боломжтой арга замуудыг таамаглаарай.

**Зорилго:** Сурагчдыг жендэрийн ялгааг тоон өгөгдөлд тулгуурлан ойлгож, шийдвэр гаргах аргачлалд сургах.

#### 2. Дасгал ажил: Төсөв зохиох

“Найз нарын баг аялын төсөв зохиож байна. Багт 2 эрэгтэй, 2 эмэгтэй байгаа. Тэд нийт 400,000 төгрөгийн төсөвтэй. Хэн хичнээн хувь зарцуулах талаар тэдэнтэй тэгш, шударга байдлаар хуваарилалт хийх санал гаргаарай.

**Зорилго:** Тэгш байдлыг тооцоолох болон зөв шийдлийг тодорхойлох.

### **3. Мэдээлэл шинжлэх бодлого**

Хотоос авсан судалгаагаар эмэгтэй сурагчдын 60%, эрэгтэй сурагчдын 75% нь математикт дуртай гэжээ. Судалгааны дүнг графикаар харуулж, энэ нь ямар хүчин зүйлээс хамаарч болох талаар тайлбарла.

**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН

## ХАВСРАЛТ

### СУРАХ БИЧИГ ЗОХИОХ МЭРГЭЖИЛТЭНД ЗОРИУЛСАН ШАЛГАХ ХУУДАС

Мэргэжилтэн өөрийн боловсруулсан сурах бичигтээ хүний эрх, жендэрийн агуулга тусгасан эсэх контент анализ хийх дүн шинжилгээний хуудас

ХҮРЭЭ	ТАЙЛБАР	АНГИЛАЛ	ТОО/ДАВТАМЖ
ДҮРҮҮДИЙН ТЭНЦВЭРТ БАЙДАЛ	Тус сурах бичигт дүрүүдийн тоо, дүрслэл тус бүр хэдэн удаа давтагдсан байна вэ?  (тооны давтамжийг тавьна уу)	Эрэгтэйчүүд	
		Эмэгтэйчүүд	
		Хүйсийг мэдэх боломжгүй	
		Үндэсний цөөнх	
		Хөдөөгийн иргэд	
		Ялгаатай гэр бүл (өрх толгойлсон, ганц бие, ижил хүйсийн)	
		Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс	
		Бэлгийн цөөнх	
		Ядуу, амьжиргааны түвшин доогуур хүмүүс	
		Ахмад настан	
		Бусад бүлгийн төлөөлөл	
ЭХ СУРВАЛЖ БОЛГОЖ АШИГЛАСАН ХҮНИЙ ТОО	Сурах бичигт эмэгтэй, эрэгтэй эх сурвалжийг тэнцвэртэй тусгасан эсэх	Эмэгтэй хүнийг эх сурвалж болгосон тоо	
		Эрэгтэй хүнийг эх сурвалж болгосон тоо	
		Эх сурвалж тодорхойгүй, эргэлзээтэй эх сурвалжийн тоо	

<b>ХҮНИЙ ЭРХЭМ ЧАНАР</b>		
Хүнийг хүндэтгэх, бусдыг хүлээн зөвшөөрөх агуулга тусгасан эсэх		
	Сурах бичигт энэ агуулга туссан.	Сурах бичигт энэ агуулга тусаагүй. Үгүй бол яагаад?
Хүмүүс хоорондын харилцаа эрх тэгш байх агуулга тусгагдсан эсэх		
Хүмүүс хоорондын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрсөн агуулга гарсан эсэх		
Эрх мэдлийн тэнцвэргүй байдлыг илэрхийлээгүй байх, хөхүүлэн дэмжээгүй байх агуулга гарсан эсэх		
<b>ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ УЯЛДУУЛСАН БАЙХ</b>		
	Сурах бичигт энэ агуулга туссан.	Сурах бичигт энэ агуулга тусаагүй. Үгүй бол яагаад?
Эрхүүдийн салшгүй, уялдаатай, харилцан хамааралтай,		
харилцан нөлөөтэйг илэрхийлсэн эсэх		
Хүний эрх эрх чөлөөг эдлүүлж байгаа жишээ тусгасан, илэрхийлэгдсэн эсэх		
<b>НИЙГМИЙН ЭГЭХ ХАРИУЦЛАГА</b>		
	Сурах бичигт энэ агуулга туссан.	Сурах бичигт энэ агуулга тусаагүй. Үгүй бол яагаад?
Хувь хүний хүлээх хариуцлага, төрийн зүгээс эгэх хариуцлагатай байх талаар тусгасан эсвэл илэрхийлсэн эсэх		
Эрхээ ухамсарлах, эрхээ мэдэх, эрхээ шаардаж байгааг илэрхийлсэн Эрх агуулагчийн тоо		
Эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах байдлаар илэрхийлсэн Үүрэг хүлээгчийн тоо		

<b>МЭРГЭЖИЛ БА НИЙГМИЙН ҮҮРЭГ</b>		
Эмэгтэй, эрэгтэй хүмүүс ямар мэргэжилтэй, ямар үүрэгтэй гарч байна вэ? Жендэрийн уламжлалт хандлага хадгалагдаж байна уу?		
	Сурах бичигт энэ агуулга туссан.	Сурах бичигт энэ агуулга тусаагүй. Үгүй бол яагаад?
Мэргэжил ба аливаа ажил үүргийн хуваарилалтыг тэнцвэртэй, хүйсийн ялгаварлалгүй тусгасан эсэх		
Хүн бүрийн нийгэмд гүйцэтгэх үүрэг, байр суурь, хариуцлагыг адил үнэлэх, тусгаж илэрхийлсэн эсэх		
<b>ЗУРАГ, КОНТЕНТЫН ДҮРСЛЭЛ</b>		
	Сурах бичигт энэ агуулга туссан.	Сурах бичигт энэ агуулга тусаагүй. Үгүй бол яагаад?
Хүчирхийлэл харуулсан, илэрхийлсэн зураг дүрслэл тусгасан уу? <i>(Хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон, өнгөлөг, гэгээлэг, хүчирхийлэл агуулаагүй зураг ашиглах)</i>		
Олон янзат байдлыг харуулсан зураг дүрслэл, хүмүүсийн түүх, амьдралын туршлагыг тэнцвэртэй тусгасан эсэх <i>(угсаатны цөөнх, бэлгийн цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй, бусад)</i>		
Агуулгад янз бүрийн мэргэжил, нас хүйс, ажил үүргийн ялгаатай байдал, хувцаслалт, биеийн хэлбэр, царай төрхөд жендэрийн хэвшмэл ойлголт илэрхийлэгдсэн эсэх		

ХЭВШМЭЛ ОЙЛГОЛТЫГ ШҮҮМЖЛЭХ АГУУЛГА		
	Сурах бичигт энэ агуулга туссан.	Сурах бичигт энэ агуулга тусаагүй. Үгүй бол яагаад?
Жендэрийн тэгш бус байдлын сөрөг нөлөөг тодорхойлсон бодит жишээ, тохиолдлыг агуулгад багтааж илэрхийлсэн үү?		
Сурагчдад жендэрийн хэвшмэл ойлголтыг таньж, шүүмжлэн дүгнэх боломж олгосон уу?		
Жендэрийн хэвшмэл хандлага, уламжлалт ойлголтуудыг задлан шинжлэхэд дэмжлэг үзүүлсэн эсэх		
ЭХИЙН АГУУЛГА, БҮТЭЦ		
	Сурах бичигт энэ агуулга туссан.	Сурах бичигт энэ агуулга тусаагүй. Үгүй бол яагаад?
Эх бүр тодорхой зорилготой, жендэрийн мэдрэмжтэй хандлагыг дэмжсэн эсэх		
Эхийн доторх дүрүүд, тэдний хоорондын харилцаа, өгүүлэмж жендэрийн эрх тэгш байдлыг тусгасан эсэх		
Эхийн бүтэц логиктой, хялбар ойлгогдохуйц байгаа эсэх		
ТЕСТ, ДАСГАЛ АЖИЛ		
	Сурах бичигт энэ агуулга туссан.	Сурах бичигт энэ агуулга тусаагүй. Үгүй бол яагаад?
Хүйсээс үл хамааран бүх сурагчдад ижил сорилт, чадварыг шалгах боломжийг олгосон эсэх		
Жендэрийн хэвшмэл ойлголтыг таних, шүүмжлэх, шийдвэрлэх чадварыг хөгжүүлэх асуултуудыг оруулсан эсэх		

	Сурах бичигт энэ агуулга туссан.	Сурах бичигт энэ агуулга тусаагүй. Үгүй бол яагаад?
Эрх мэдэл, манлайлал эрэгтэй, эмэгтэй дүрүүдийн манлайлыг тэнцвэртэй тусгасан эсэх. Шийдвэр гаргах түвшинд тэнцвэртэй дүрслэгдэж байна уу?		
Сурах бичигт хүний эрх, жендэрийн агуулга сурагчдад тэгш хүртээмжтэй, ойлгомжтой туссан эсэх		
Сурах бичигт ямар нэг байдлаар ялгаварлан гадуурхах үзэл, хүйсээр, орлогын болон хөгжлийн ялгаатай байдлаар ялгаварлах хандлагыг тусгахгүй байх		

## ГУРАВДУГААР ХЭСЭГ: ХИЧЭЭЛ, ПРАКТИКТ ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ХАНДАХ НЬ

Жендэрийн мэдрэмжтэй үг хэллэг хэрэглэх нь

Боловсролын орчинд хэрэглэгдэж буй үг хэллэг нь сурагчдын өөрийгөө үнэлэх үнэлэмж, нийгмийн дүр төрх хандлагад хүчтэй нөлөөлдөг. Жендэрийн мэдрэмжтэй үг хэллэг хэрэглэх гэдэг нь хүйсийг ялгаварлан харуулахгүй, бүх хүнийг оролцуулсан, тэгш байдлыг илэрхийлсэн, ялгаварлалгүй хэл зүйн хэрэглээг сонгохыг хэлнэ. Жендэрийн мэдрэмжтэй үг хэллэгийг хэрэглэж хэвших нь сурагч бүрийн өөрийгөө илэрхийлэх, тэгш эрхтэй оролцох, үнэлэгдэх суурь нөхцөлийг бүрдүүлдэг чухал алхам юм.

Мөн боловсролын орчинд хэн нэгнийг хүйс, үүрэг, зан чанарт тулгуурлан тодорхойлсон үг хэллэг нь хүүхдийн сэтгэлзүй, итгэл үнэмшил, сонголтод нөлөөлдөг. “Эмэгтэй хүүхэд зөөлөн ааштай байх ёстой”, “эрэгтэй хүүхэд эрэмгий, хүчтэй байх хэрэгтэй” зэрэг үг хэллэг нь хүйсийн тогтсон хүлээлтийг бий болгодог. Үүнийг задлахын тулд хүйсэд төвлөрсөн бус, олон талт, уян хатан утгатай хэллэгийг санаатай хэрэглэж хэвших хэрэгтэй. Жишээлбэл, “хүн бүрийн үүрэг” гэдгийг “эмэгтэйчүүдийн ажил” гэж, “удирдагч” гэдгийг “эрэгтэй хүн” гэж ойлгох хэвшмэл хандлагыг халах хэрэгтэй. Жишээлбэл:

- *Эмэгтэй хүн гэрийн ажил хийхдээ илүү сайн гэж хэлэхийн оронд Хүн бүр гэрийн ажил хийх чадвартай*
- *Эрэгтэй хүн удирдагч байж чаддаг гэж хэлэхийн оронд Удирдагч байх нь тухайн хүний чадвар, зан чанараас шалтгаална гэх мэт*
- *Охид ихэнхдээ даруухан байдаг гэж хэлэхийн оронд Бүх хүүхэд өөрийн бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй*
- *Эрэгтэй хүн уйлдаггүй гэж хэлэхийн оронд Бүх хүн сэтгэл хөдлөлөө илэрхийлэх эрхтэй*

Сурагчдын сурах бичиг дэх зургууд нь зөвхөн мэдээлэл дамжуулаад зогсохгүй, жендэрийн үүрэг, нийгмийн байр суурийг үлгэрлэх нөлөөтэй. Харамсалтай нь Монголын олон сурах бичигт эрэгтэй, эмэгтэй хүнийг уламжлалт үүргээр нь дүрслэх хэвшмэл хандлага давамгайлдаг гэдгийг судалгаа, дүн шинжилгээний дүгнэлтээс бид харсан билээ. Тухайлбал, эрэгтэйг гадаа ажил хийж буй, эмэгтэйг гал тогоонд хоол хийж буй байдлаар зурсан зураг олон давтагдаж байсан. Сурах бичгийн

- Үйлдлийн хувьд: Эмэгтэй хүн техникийн багаж ашиглаж буй, эрэгтэй хүн хүүхэд асарч буй.
- Байршлын хувьд: Эмэгтэй хүн ууланд аялж буй, эрэгтэй хүн номын сан дотор ном уншиж буй

- Амьдралын хэв маягаар: Өрх толгойлсон аав гэрийн ажлыг хийж буй, өндөр настай эмэгтэй хамт олон удирдаж буй гэх мэтээр дүрсэлж болно.

## **ДЭЛГЭРҮҮЛЖ УНШИХ БОЛОМЖТОЙ ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ**

1. **Жендэрийн мэдрэмжтэй текст бичих:** НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс гаргасан “Жендэрийн мэдрэмжтэй хэл найруулгын гарын авлага” нь текст бичихдээ жендэрийн тэгш байдлыг хэрхэн хангах талаар дэлгэрэнгүй зөвлөмж өгдөг. (“UNDP Guidelines for Gender-Sensitive Language” (2016)
2. **Жендэрийн тэгш байдлыг харуулсан дүрслэл ашиглах:** ЮНЕСКО-гийн “Сурах бичигт жендэрийн тэгш байдлыг хангах удирдамж” баримт бичигт сурах бичгийн зураг, графикт жендэрийн тэгш байдлыг хэрхэн тусгах талаар зөвлөмжүүд багтсан. (“Promoting Gender Equality through Text-books: A Methodological Guide” (2009)
3. **Жендэрийн тэгш байдлыг хангасан кейс, жишээ ашиглах:** Олон улсын боловсролын судалгааны төвүүдийн гаргасан “Сурах бичигт жендэрийн мэдрэмжийг тусгах аргачлал” гарын авлагад кейс, жишээг хэрхэн сонгох талаар зөвлөмжүүд байдаг. (“Gender-Sensitive Communication Guidelines” (2018)
4. **Сурах бичгийн хэл найруулгад жендэрийн мэдрэмжийг тусгах:** Европын Холбооны “Жендэрийн мэдрэмжтэй хэл найруулгын удирдамж” баримт бичигт хэл найруулгад жендэрийн мэдрэмжийг хэрхэн тусгах талаар дэлгэрэнгүй зөвлөмжүүд багтсан.
5. **Хяналт, үнэлгээний систем нэвтрүүлэх:** Дэлхийн Банкны боловсруулсан “Боловсролын салбарт жендэрийн тэгш байдлыг хангах хяналт, үнэлгээний аргачлал” баримт бичигт хяналт, үнэлгээний системийг хэрхэн нэвтрүүлэх талаар зөвлөмжүүд багтсан.
6. **Багш нарт зориулсан заах арга зүй:** ЮНЕСКО-гийн “Багш нарт зориулсан жендэрийн мэдрэмжтэй заах арга зүйн гарын авлага” баримт бичигт багш нарт жендэрийн мэдрэмжтэй заах арга зүйн талаар зөвлөмжүүд багтсан. (“Communicating on Gender Equality and Education” (2022)
7. **Жендэрийн талаарх мэдээлэл багтаах:** НҮБ-ын Хүүхдийн сангийн “Сурах бичигт жендэрийн тэгш байдлыг тусгах удирдамж” баримт бичигт жендэрийн талаарх мэдээллийг хэрхэн багтаах талаар зөвлөмжүүд байдаг.

## **ЕБС-ИЙН СУРАГЧДАД УНШУУЛАХ БОЛОМЖТОЙ ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ УРАН ЗОХИОЛЫН ЖАГСААЛТ**

### **Монголын уран зохиол**

1. Шанжмятавын Гаадамба - “Элбэг дээл”, Жендэрийн хэвшмэл ойлголтыг ойлгож, шүүмжлэх боломжтой өгүүллэг.

2. Гайхамшигт 50: Урам зоригийн түүх, Ч.Бат-Уянга, Энэ бол Монгол хэмээх нэрийн дор багтаж яваа, Монгол хэмээх нэгэн улсыг өргөж яваа ард түмний тэн хагас нь болох эмэгтэйчүүдийн туулж, бүтээж ирсэн амьдралын түүх юм.
3. Ч.Лодойдамба - “Тунгалаг Тамир”, Түүхэн зохиолын хүрээнд эмэгтэй ба эрэгтэй дүүргийн тэгш оролцоог шүүмжлэх боломжтой.
4. Л.Түдэв - “Хорвоотой танилцсан түүх”, Залуу уншигчдад ертөнцийн олон янз байдлыг ойлгуулах, хүйсийн ялгаварлалгүй орчинд суралцах боломж олгоно.

#### Гадаадын уран зохиол

1. Луиза Мэй Олкотт - Little Women
  - Эмэгтэй дүүргийн тусгаар тогтнол, боловсролын эрхийг хөндсөн.
2. Харпер Ли - To Kill a Mockingbird
  - Арьс өнгөний үзэл болон хүйсийн тэгш эрхийн асуудлыг хөндсөн.
3. Жейн Остин - Pride and Prejudice,
  - Эмэгтэй хүний байр суурь, хүйсийн тэгш бус байдал, нийгмийн хандлагыг шүүмжилсэн.
4. Шарлотте Бронте - “Жэйн Эйр” (Jane Eyre)
  - Эмэгтэй дүүргийн бие даасан байдал, амьдралын сонголттой холбоотой.
5. Малала Юсуфзай - “Малала” (I Am Malala)
  - Охидын боловсрол, эрх чөлөөний төлөөх тэмцлийг харуулсан бодит түүх.
6. Анна Франк - “Анна Франкийн өдрийн тэмдэглэл” (The Diary of a Young Girl)
  - Залуу охины зовлон, урам зоригийг жендэрийн өнцгөөс ойлгоход тустай.
7. Маргарет Этвуд - “Шивэгчний үлгэр” (The Handmaid’s Tale)
  - Эмэгтэйчүүдийн эрх чөлөө, бие даасан байдалд хязгаарлалт тавьсан нийгмийн шүүмж.
8. Жорж Орвелл - “Амьтны ферм” (Animal Farm)
  - Эрх мэдэл, тэгш эрхийн тухай аллегоори, жендэрийн асуудал хөндөх боломжтой.
9. Элинор Портер - “Полианна” (Pollyanna)
  - Залуу охины үзэл бодол, жендэрийн ялгаварлалгүй ертөнцөд амьдрах үзэл санааг агуулсан.

## ◆ НЭР ТОМЬЕОНЫ ТАЙЛБАР

### АСРАХУЙН ХӨДӨЛМӨР (Care work)

Асрахуйн хөдөлмөрийг хамааралтай хүмүүс болох хүүхэд, өвчтөн, өндөр настныг цалин хөлсгүй асран халамжлах үүрэг хариуцлагатай голцуу холбон ойлгодог. Гэтэл асрахуйн хөдөлмөр гэдэг нь өөрөөс хамааралтай болон хамааралгүй этгээдүүдийн төлөө цалингүй эсвэл цалин хөлстэй хийж буй бүхий л ажил үүрэг юм. Хүмүүст боломж чадвараа нэмэгдүүлэх, амьдралдаа хүсч буй зүйлдээ хүрэх боломж олж авахад нь туслах ажил мэргэжлүүдийг, жишээлбэл хүүхэд асрах болон бүх түвшний сурган хүмүүжүүлэх, эрүүл мэндийн бүх төрлийн тусламж үйлчилгээ үзүүлэх ажлуудыг энд багтаан ойлгож байна. Асрахуйн хөдөлмөрт мөн гэр орны цалин хөлсгүй ажил багтана. Асрахуйн хөдөлмөр нь цалин хөлстэй ажил, мэргэжил хэлбэрээр гүйцэтгэгдсэн үедээ доогуур зиндааны, бага цалинтай ажил байх нь түгээмэл. Харин цалин хөлсгүй гүйцэтгэгдэх үедээ эмэгтэйчүүдийн ажил үүргийн нэг хэсэг мэт ойлгогддог.

### БОЛОВСРОЛ БА ЖЕНДЭР (Education and gender)

Боловсролын хүрээн дэх жендэрийн тэгш байдал нь охид хөвгүүд, эрэгтэй эмэгтэй хүмүүсийн насан туршийн сурч боловсрох, олж авсан мэдлэг чадвараа ашиглан ажил хөдөлмөр эрхлэх, хөгжиж дэвших тэгш боломж бололцоотой байх тухай болон боловсролын тухай хууль дүрэм, стандарт, хөтөлбөр, сургалтын орчин, ном сурах бичиг, заах сурах арга барилыг хамарсан өргөн хүрээний ойлголт юм. Боловсролын агуулга нь охид хөвгүүд, эрэгтэй эмэгтэй хүмүүсийн жендэрийн практик ба стратеги хэрэгцээг хангахад чиглэсэн байх ёстой бөгөөд үүний тулд өнөөгийн нийгэмд тэдэнд тулгарч буй асуудлыг жендэрийн шинжилгээтэй илрүүлэх, түүнийг сургалтын хөтөлбөрт тусгах, боловсролын салбарт багш, нийгмийн ажилтнуудын жендэрийн боловсролыг дээшлүүлэх зэрэг цогц арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай. Монгол Улсын боловсролын салбарт баримтлах жендэрийн бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөөг БСШУ-ны сайдын тушаалаар 2018 онд батлан хэрэгжүүлж эхэлсэн.

### БЭЛГИЙН ЧИГ БАРИМЖАА (Sexual orientation)

Бие махбод, хайр дурлал, зүрх сэтгэлийн хувьд аль нэг, эсвэл аль аль хүйсийн хүмүүст татагдах төрөлхийн мөн чанарыг бэлгийн чиг баримжаа гэнэ. Энэ нь хэн нэгний, оролцоотой, эсвэл хүчээр биш, байгалиас заяасан өөрийн мэдэлгүй төрдөг мэдрэмж юм. Бэлгийн чиг баримжаа гурван төрөл байдаг. Үүнд: гетеросексуал буюу эсрэг хүйсийнхээ хүмүүст татагддаг бэлгийн чиг баримжаа (стрэйт), лесбиян, гей буюу ижил хүйсийнхээ хүмүүст татагддаг бэлгийн чиг баримжаа, бисексуал буюу аль аль хүйсийн хүмүүст татагддаг бэлгийн чиг баримжаа багтана. Бэлгийн чиг баримжааны дараах хэлбэрүүдийг тодорхойлж байна. Үүнд:

- Лесбиян (Lesbian)- Бие махбод, хайр дурлал, сэтгэл зүрхний хувьд бусад эмэгтэйчүүдэд татагддаг эмэгтэй хүн.
- Гей (Gay)- Бие махбод, хайр дурлал, сэтгэл зүрхний хувьд бусад эрчүүдэд татагддаг эрэгтэй хүн.
- Бисексуал (Bisexual)- Бие махбод, хайр дурлал, сэтгэл зүрхний хувьд өөрийн болон бусад хүйсүүдэд татагддаг хүмүүс.
- Трансжендэр (Transgender)-Төрөлх болон бусдын хүлээж буй хүйсээс өөр хүйсээр өөрийгөө илэрхийлдэг хүн.
- Интерсекс (Intersex)- Нөхөн үржихүйн болон бэлгийн төрөлхийн өөрчлөлттэй, өөрөөр хэлбэл эр болон эм хүйсэнд үл харьяалагдах “хэвийн” бус гаднах бэлэг эрхтэн болон доторх нөхөн үржихүйн эрхтэнтэй төрсөн хүмүүс. Тэдний хромосом (XXY, XXX, XYU гэх мэт), дааврууд (дотоод шүүрлийн үйл ажиллагаа), бэлгийн булчирхай (төмсөг, өндгөвч) болон/эсвэл маш жижиг шодой эсвэл маш том хэлүү зэрэг нөхөн үржихүйн эрхтний бүтэц нь ялгаатай байдаг.
- Күйр (Queer)- Бэлгийн зан үйл болон хүсэл тэмүүллийн түвэгтэй, олон янз байдлыг хялбар илэрхийлэх нэгдсэн нэршил. Энэ нь “уламжлалт” бус бэлгийн чиг баримжаа, хүйсийн илэрхийлэл бүхий хүмүүсийн нийтлэг нэршил.
- Асексуал (Asexual)- Бие махбодийн хувьд бусдад татагддаггүй хүн. Тэд хайр дурлал, сэтгэл зүрхний хувьд бусдад татагдах болон татагдахгүй байх боломжтой.

## **ЖЕНДЭР (Gender)**

Жендэр нь эмэгтэй, эрэгтэй хүний биологийн онцлог төдийгүй эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн гэр бүл, нийгэм дэх дүр төрх, үнэ цэн, ажил үүрэг, байр суурь, хүлээлт зэрэг нийгэм соёлоос шалтгаалсан дүр төрх, нөхцөл байдлыг цогцоор нь илэрхийлдэг. Тиймээс жендэрийг “нийгмийн хүйс” гэж болно. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай Монгол Улсын хуульд “жендэр” гэж улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, тэдний нийгэмд эзлэх байр суурийн талаар уламжлагдан тогтсон, түүхэн явцад хувьсан өөрчлөгддөг ойлголт, үзэл, хандлага гэсэн утгаар ойлгоно гэж тусгасан байна. Хүйс буюу эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн биологийн ялгаа тогтвортой байдаг бол жендэрийн агуулга нь нийгэм соёл бүрт харилцан адилгүй бөгөөд цаг хугацаанд хувиран өөрчлөгдөж байдаг. Жендэр нь нийгмийн анги давхраа, нас, арьс өнгө/яс үндэс, шашин шүтлэг, газарзүй, эдийн засаг, улс төр, соёл, гэр бүлийн орчин зэрэг олон үзүүлэлттэй харилцан хамааралтай.

## **ЖЕНДЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ (Gender analysis)**

Жендэрийн дүн шинжилгээ нь хөгжлийн бодлого төлөвлөлт, хөтөлбөр, төсөл,

хүн амд чиглэсэн үйл ажиллагаанд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ялгаатай хэрэгцээ, гүйцэтгэж буй үүргийг бүрэн тусгах, оролцоог тэгш шударга байлгах зорилгоор хийдэг дүн шинжилгээний төрөл юм.

### **ЖЕНДЭРИЙН ДҮР (Gender roles)**

Эр, эм хүйсийн талаарх нийгэм соёлын итгэл үнэмшил нь эрэгтэй, эмэгтэй хүмүүст харилцан адилгүй үүрэг буюу дүрийг ногдуулж байдаг. Жендэрийн дүр эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хэн хэнд тодорхой үүрэг хариуцлага ногдуулахын зэрэгцээ үйл ажиллагааг нь хязгаарлаж байдаг. Жендэрийн дүр нь дэлхий дахинд эмэгтэйчүүдийн хараат, захирагдмал байдлыг хэвээр хадгалах гол хүчин зүйл болдог. Хүйсийн тогтвортой ялгаанаас үүдэн жендэрийн дүрийг ч мөн хувирч өөрчлөгдөшгүй мэт үзэх хэвшмэл ойлголт байдаг. Гэвч жендэрийн дүр нь нийгэм соёл, анги давхраа бүрт ялгаатай бөгөөд боловсрол, технологи, эдийн засгийн хөгжил, дайн тулаан, өлсгөлөн, уур амьсгалын өөрчлөлт зэргийн улмаас байнга хувьсдаг.

### **ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДАЛ (Gender equality)**

Жендэрийн тэгш байдал гэдэг нь эмэгтэй, эрэгтэй хүмүүс нийгмийн болон хувийн амьдралын хүрээнд эн тэгш үнэлэгдэж, тэгш эрх мэдэл, оролцоотой байна гэсэн үг юм. Тэгш байдлыг анхандаа хүмүүст хувийн болон бүлгийнх нь нөхцөл байдлаас үл шалтгаалан нэгэн адил байдлаар хандах явдал гэж ойлгож байжээ. Гэтэл тэгш бус нөхцөлд тэгш хандах гэж оролдох нь ялгавартай байдлыг улам ихэсгэдэг. Үүнийг таньж мэдсэнээр жендэрийн тэгш байдлыг эмэгтэй, эрэгтэй хүмүүст ялгаагүй хандах бус, харин тэдний ялгаатай хэрэгцээг харгалзан нөхцөл байдлыг нь адил тэгш болгоход анхаарах явдал гэж ойлгох болсон байна. Жендэрийн тэгш байдал нь тогтвортой хөгжлийн салшгүй бүрдэл хэсэг, “Хэнийг ч үл орхигдуулах” зарчмыг хэрэгжүүлэх арга зам болж байна.

### **ЖЕНДЭРИЙН ТЭГШ ЭРХ (Gender equity)**

Жендэрийн (хүйсийн) тэгш эрх гэж эрэгтэй, эмэгтэй хүмүүст тэдний тусгай буюу өвөрмөц хэрэгцээ, сонирхлынх нь дагуу тэгш шударга хандахыг хэлнэ. Энэ нь адил тэгш хандах, эсвэл ялгаатай боловч эдлэх эрх, хүртэх ашиг, хүлээх хариуцлага, боломж бололцооны хувьд адил тэгш байхуйцаар хандах тухай ойлголт юм. Хүйс, орлого, арьсны өнгө, гарал угсаа зэрэг шинжүүдээр ялгаварлагдахаас хүмүүсийг хамгаалахын тулд ялгаварлан гадуурхалтыг хуулиар хориглохоос гадна шударга бус байдлыг залруулах, нөхөн сэргээх арга хэмжээ авах нь хүйсийн тэгш эрхийг хангах арга зам болдог. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай Монгол Улсын хуульд жендэрийн тэгш эрхийг эрэгтэй, эмэгтэй хүн бүр улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, гэр бүлийн ба бусад харилцаанд тэгш эрхтэй байх, нийгмийн амьдралд адил оролцох, хөгжлийн үр шим, нийгмийн баялгаас тэнцүү ашиг хүртэх боломж, нөхцөл хангагдсан байх гэж тодорхойлсон байна.

## ЖЕНДЭРИЙН ХЭВШМЭЛ ОЙЛГОЛТ (Gender stereotype)

Жендэрийн хэвшмэл ойлголт (стереотип) нь эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн, тодорхой бүлгүүдийн шинж төрх, ялгаа, гүйцэтгэх үүргийн талаар нийгэм соёлын нөлөөгөөр төлөвшин тогтсон хялбаршуулсан ерөнхий ойлголт юм. Жендэрийн хэвшмэл ойлголт нь эерэг, сөрөг ямар ч байсан бусдын талаар тодорхой бодитой мэдээлэл болж чаддаггүй бөгөөд шударга бус хандахын, аливаа шударга бус байдлыг зөвтгөхийн үндэс болж байдаг. Жендэрийн хэвшмэл ойлголт нийгэм, соёл бүрт харилцан адилгүй ч эмэгтэйчүүдийн захирагдмал, хамааралтай байр суурийг хадгалж бэхжүүлсэн түгээмэл шинжтэй байдаг. Тухайлбал эмэгтэй хүнийг гэрлэж, олон хүүхэд төрүүлдэг, гэр бүлийнхээ сайн сайхны төлөө өөрийгөө золиослогч, асран халамжлагч, сайхан эелдэг зөөлөн зан дуулгавартай, дур булаам, үзэсгэлэнтэй гэх зэрэг, харин эрэгтэй хүний тухайд өрх гэрийг тэжээгч, бие даасан, эрэлхэг, сэтгэл хөдлөлөө барьдаг гэх зэрэг хэвшмэл ойлголт түгээмэл. Ийм маягийн хэвшмэл ойлголтууд нь эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн гүйцэтгэх үүрэг, эзлэх байр суурийн талаар харилцан адилгүй хэм хэмжээг нийгэмд тогтоон хүлээлт үүсгэж, жендэрийн дүрийг хувь хүмүүст тулгаж байдгаараа хувь хүний хөгжил дэвшил, өөрийгөө илэрхийлэхэд ихээхэн садаа болдог.

## ЖЕНДЭРИЙН ЯЛГААТАЙ БАЙДАЛ (Gender gap)

Жендэрийн ялгаатай байдал (зөрүү, зөрүүтэй байдал) нь үйлчилгээ, хөрөнгө нөөц болон эрх мэдлээс хүртэх, оролцоход эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн хооронд оршин байгаа ялгаа юм. Эдгээр ялгаатай байдал нь гол төлөв эрэгтэйчүүдийн давуутай байдлаар илэрдэг бөгөөд нийгмийн зан заншлын хүрээнд хэвшин тогтсон байхаас гадна хууль тогтоомж, бодлого зохицуулалтаас улбаатай буюу тэдгээрээр бэхжсэн байх нь ч бий. Хүний хөгжил, нийгэм соёл, улс төр, эдийн засгийн нөхцөл байдлын аливаа нэг үзүүлэлт өөр хүйсийн хүмүүсийн хувьд харьцангуй ялгаатай байхыг жендэрийн зөрүү гэнэ. Жишээ нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж цалингийн зөрүүг цалин хөлсний жендэрийн ялгаатай байдал буюу зөрүү гэнэ. Дэлхий нийтэд эмэгтэйчүүд ихэвчлэн эрэгтэйчүүдээс бага цалин авдаг. Тухайлбал, 2023 онд дэлхий дахины цалин хөлсний жендэрийн зөрүү 0.83 байна. Энэ нь эмэгтэйчүүдийн дундаж цалин эрэгтэйчүүдийн дундаж цалингийн 83 хувьтай тэнцэж байна гэсэн үг юм. Жендэрийн зөрүүг мөн үндэсний, салбарын, байгууллагын зэрэг аль ч түвшинд тооцон гаргаж болно. Манай улсад дундаж наслалтын жендэрийн зөрүүгээр эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс дунджаар 10 орчим жилээр богино насалж байна. Энэ мэтчилэн хүйсээр ангилсан харьцуулах боломжтой аливаа мэдээллээс жендэрийн зөрүү буюу ялгаатай байдал байгаа эсэхийг харж болно.

## ПАТРИАРХИ ЁС (Patriarchy)

Патриархи ёс гэж эдийн засаг, нийгэм соёлын амьдралд эрэгтэйчүүд давамгайлж, эмэгтэйчүүд хараат буюу захирагдмал байр суурьтай байх

тогтолцоог хэлнэ. Ийм тогтолцоо нь эрэгтэйчүүдийг эмэгтэйчүүдээс илүүд үзэх, үүнийг байгалийн жам ёсны үзэгдэл гэх, эсхүл соёл уламжлалаар зөвтгөх патриархи буюу эцгийн эрхт ёсны үзэл дээр тулгуурладаг. Патриархи ёс нь жендэрийн тэгш бус байдлын, түүний дотор эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн үндэс суурь болдог бөгөөд эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн нийгэмд эзлэх байр суурь, гүйцэтгэх үүргийн талаарх жендэрийн хэвшмэл ойлголтыг агуулж байдаг.

## **УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ БА ЖЕНДЭР (Gender and climate change)**

Уур амьсгалын өөрчлөлт хүн амын бүлгүүдэд, эмэгтэй эрэгтэй хүмүүст харилцан адилгүй нөлөөлдөг нь тэдний нийгэм соёлоор нөхцөлдсөн амьдралын хэв маяг, жендэрийн ялгаатай дүр, үүргээс төдийгүй, тэдэнд чиглэсэн бодлого, арга хэмжээ жендэрийн хувьд харалган байгаагаас үүдэлтэй. Эмэгтэй, эрэгтэй хүмүүс засаглалын үйл явцад харилцан адилгүй оролцож, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг үр дагаврыг даван туулах нөөц боломжийг тэгш бус хүртэж байгаа нөхцөлд уур амьсгалын өөрчлөлт жендэрийн зөрүү улам гүнзгийрнэ. Тиймээс уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой шийдвэр гаргах бүх түвшин, үе шатанд эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн ялгаатай нөхцөл байдал, мэдлэг туршлагыг харгалзан үзэх шаардлагатай. Хөгжлийн бэрхшээлтэй, ахмад настан хүмүүс зэрэг эмзэг бүлгүүдийг уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, түүний сөрөг үр дагаврыг даван туулахад нь туслах үйл ажиллагааг орон нутагт зохион байгуулахдаа эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн оролцоог хангах нь тэдний хамтын ажиллагаа, харилцан ойлголцлыг хөгжүүлэх арга зам болно.

## **ХҮЙС (Sex)**

Хүйс нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн биологийн ялгааг илэрхийлдэг. Хүйсийн ялгаа нь генээр тодорхойлогддог нийтлэг, үл өөрчлөгдөх чанар бөгөөд сэтгэл хөдлөл, зан үйл дэх зарим ялгаатай байдлын уг шалтгаан болдог. Гэвч хүйс нь дангаараа хүнийг тодорхойлж чадахгүй, нийгэм соёлын нөлөөг илэрхийлэхгүй. Мөн хүйс нь дангаараа эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн нийгэмд эзэлж буй ялгаатай байр суурийг тайлбарлаж чаддаггүй.

## **ФЕМИНИЗМ (Feminism)**

Феминизм нь иргэний эрхийг эмэгтэй, эрэгтэй хүмүүст эн тэгш эдлүүлэх зорилготой нийгмийн хөдөлгөөний ерөнхий нэр юм. Феминизм нь эрх тэгш байдлын тухай улс төрийн шинэ онолыг үүсгэсэн. Феминизм нь өнөөдөр 1) эмэгтэйчүүдийн дарлагдмал, захирагдмал байдлын талаарх онол; 2) эмэгтэйчүүдийг эрэгтэйчүүдийн давамгайлал болон мөлжлөгөөс чөлөөлөхөд чиглэсэн нийгэм, улс төрийн онол болон практик үйл ажиллагаа; 3) жендэрийн болон анги давхрааны хэвшмэл тогтолцоог эсэргүүцсэн нийгмийн хөдөлгөөн, мөн 4) эмэгтэйчүүдийг дорд үзэх, ялгаварлан гадуурхах аливаа үзэл бодол, үйлдлийн эсрэг үзэл санаа болж байна.

## **ЭМЭГТЭЙЛЭГ БА ЭРЭГТЭЙЛЭГ ШИНЖ (Femininity and Masculinity)**

Эмэгтэйлэг ба эрэгтэйлэг шинж гэж эр, эм хүйсийн тухайд нийгмийн зүгээс тавьж буй хүлээлт, нийтлэг ойлголтын цогцыг хэлдэг. Энэ бол биеийн хүч чадал, үр бүтээлч байдал, асран халамжлах чадвар, гоо сайхан зэрэг хүнийг тодорхойлдог бүх л шинж чанаруудыг эмэгтэй, эрэгтэй хүмүүст ялгаатай байдлаар хамруулан үзэх тухай ойлголт юм. Эмэгтэйлэг, эрэгтэйлэг шинж нь хүйсийн анхдагч болон хоёрдогч шинжээр тодорхойлогдох биологийн утга агуулгаар, мөн нийгэм соёлоос эмэгтэй, эрэгтэй хүмүүст хамаатуулж буй бодит болон билэгдлийн шинжтэй дүр, үүргээр тодорхойлогддог. Эмэгтэйлэг ба эрэгтэйлэг шинжүүд нь нийгэм соёл бүрт ялгаатай бөгөөд гадны хүчин зүйлсийн нөлөөгөөр цаг хугацаанд өөрчлөгдөж байдаг. Эмэгтэйлэг, эрэгтэйлэг шинжүүд нь тухайн нийгэм соёлд бүрэлдэн тогтсон жендэрийн хэвшмэл ойлголтын тусгал байдаг бөгөөд нилээд хатуу загвар, хэм хэмжээг хувь хүмүүст тулгаж байдгаараа жендэрийн хүчирхийлэл үүсэх үндэс суурь болох нь элбэг.

## **ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ (gender-based violence)**

гэж жендэрээс үүдэлтэйгээр бусдад бие махбодийн, бэлгийн, сэтгэл санааны гэм хор, эдийн хохирол учруулсан, учруулж болзошгүй үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ. (Жендэрийн тэгш байдлыг хангах тухай. МУ-ын хууль. 4.1.8)

## **ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛ (inclusive education)**

нь бүх суралцагчдын нийгэм, соёл, боловсролын үйл ажиллагаан дахь тэгш оролцоог хангах, боловсролын гаднах болон доторх бүх хэлбэрийн ялгаварлан гадуурхалтыг бууруулах замаар сурагч бүрийн ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн боловсролын үйлчилгээг хүргэх үйл явц мөн. Суралцагсдын харилцан адилгүй байдал, ялгаатай хэрэгцээ, хэл соёл, нийгмийн гарал, эдийн засгийн хүчин зүйлсээс үл хамааран хүн бүрийн мэдлэг чадвараа дээшлүүлэх, боловсрол эзэмших тэгш боломж болон эрхийг хангахад чиглэсэн үйл явц юм. (Юнеско-ийн Монголын Үндэсний комисс, 2014).

## **ТЭГШ ХАМРУУЛАН СУРГАХ (inclusive education)**

боловсрол нь суралцагч бүрийг эрх эдлэгч гэж үздэг, тэднийг сургуулийн нэгэн булангаас анхаарлын төвд авчирдаг. Энэ нь хувь хүний бэрхшээлээс илүү нийгмийн нөхцөл байдалд анхаарлыг шилжүүлж байгаа хэрэг юм. Тэгш хамруулан сургах тогтолцоо нь хүүхэд боловсролын тогтолцоонд зохицохоос илүү боловсролын тогтолцоо хүүхдэд зохицохыг баталгаажуулахын тулд боловсрол, орон нутгийн, бүлгийн өөрчлөлтийг дэмждэг. Тэгш хамруулан сургах тогтолцоо нь хувь сурагчдын ялгаатай хэрэгцээнд тохируулах, тэр боломжид саад болж байгаа саад тотгорыг арилгахын тулд сургууль дахь соёл, бодлого, практик үйл ажиллагааг өөрчлөн зохион байгуулах шаардлагыг хүлээн зөвшөөрдөг.

## **ХҮНИЙ ЭРХ (human rights)**

Хувь хүн болон нийгмийн бүлгийн байгалиас заяамал эрхийг зөрчигдөж, алдагдахаас хамгаалах суурь эрхийн баталгааны цогц юм. Эдгээр эрх хүн бүрт тэгш заяагдсан ба өөр хэн нэгэн дэлхийн аль ч хэсэгт, ямар ч тохиолдолд, ямар ч шалтгаанаар энэ эрхийг нь зөрчих ёсгүй. Хүний эрхийг салшгүй, хуваагдашгүй, харилцан хамааралтай гэж тодорхойлдог. (Монголын Эмнести интернэшнл “Хүүхдэд ээлтэй сургууль болох нь” гарын авлага)

## **ХҮНИЙ ЭРХЭД СУУРИЛСАН ХАНДЛАГА (human rights-based approach)**

хүний эрхэд суурилсан хандлага гэдэг нь олон улсын хүний эрхийн жишиг хэмжээнд тулгаарлан хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих замаар хүнийг хөгжүүлэх үйл явцын цогц суурь юм. Энэ нь хөгжлийн асуудлаас хамааран үүссэн тэгш бус байдлыг халах, алагчлах байдлыг жигшиж, хөгжлийн үйл явцад саад болох шударга бус эрх мэдлийг зогсооход оршино. (Ази Номхон далайн форум, 2015 он, “Хүний эрхийн боловсрол”)

## **ҮНДЭСТНИЙ ЦӨӨНХ (Ethnic minority)**

бол тухайн улсад зонхилох байр суурь эзэлдэггүй бөгөөд тодорхой үндэстэн, угсаатан, шашин шүтлэг, эсвэл хэлний хувьд олонх хүн амаас ялгардаг хувь хүмүүс юм (UNCHR, Fact sheet no18, Minority rights) Үндэстний цөөнх гэдэг нь тухайн улсын хүн амын дийлэнхтэй харьцуулахад тооны хувьд цөөн бөгөөд хэл, арьсны өнгө, соёл иргэншлийнхээ хувьд ялгарах өөрсдийн өвөрмөц байдлыг хадгалах хүсэл эрмэлзэл бүхий тодорхой бүлэг хүмүүс юм (ХЭҮК, 2010).

## **ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭД (human rights)**

гэдэгт бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан, 18 нас хүрээгүй хүн бүрийг (Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай. МУ-ын хууль. 4.1.1, Хүүхдийн эрхийн тухай конвенц)

## **ЯЛГААТАЙ ХЭРЭГЦЭЭ**

Ялгаатай хэрэгцээ” гэж хүний боловсрол эзэмшихтэй холбоотой хөгжлийн бэрхшээл, онцгой авьяас, хэл, соёл, жендэр, нийгэм, эдийн засаг, байршлын ялгаанаас үүдэлтэй хэрэгцээг.



## “БҮХ НИЙТ БОЛОВСРОЛЫН ТӨЛӨӨ!” ИРГЭНИЙ НИЙГМИЙН ҮНДЭСНИЙ ЭВСЛИЙН

### ТУНХАГ

Боловсрол нь хүн бүрийн өдөр тутмын амьдралд, насан турш нөлөөлөх үндсэн эрх, хүний хөгжлийн түлхүүр бөгөөд иргэн бүрт чанартай боловсрол олгох нь төрийн хүлээх гол үүрэг хариуцлага гэдэгт итгэн;

Өнөөгийн тогтолцоонд боловсролыг явцуу тодорхойлдог, хүн бүрийн ялгаатай байдлыг харгалздаггүй, ялгаварлан гадуурхдаг, хангалттай санхүүжилт олгодоггүй зэргээс шалтгаалан бодлого төлөвлөх, хэрэгжүүлэх үйл явцад цогц хандлага дутагдаж; боловсролын тогтолцооны үр өгөөж нь хувь хүний хүсэл тэмүүлэл, нийгмийн эрэлт хэрэгцээнээс асар зөрүүтэй байсаар ирсний улмаас үнэ цэнэтэй амьдарч, амьдралын чанараа дээшлүүлэх боломж олгохгүй байгаад сэтгэл зовнин;

Энэ нь эрх мэдлийн шударга бус бүтцийг бий болгож, тэгш бус байдлыг хадгалж үлдэх арга зам болж байгааг эсэргүүцэн;

Боловсролын чанар, хүртээмж, хариуцлагатай байдлын төлөө хүчээ нэгтгэн ажиллаж, энэ үйл явцад хувь хүн, иргэний нийгмийн байгууллага, бүлгүүдийг өргөнөөр татан оролцуулж, өргөн суурьтай, зохион байгуулалттай, хүчтэй хөдөлгөөн бий болгохыг чухалчлан;

Энэ үйл явцад нийгмийн бүх бүлэг, ялангуяа эрх мэдлийн цөөнхийн оролцоог хангахыг онцлон;

Иргэд, бүлгүүдийн мэдлэг, чадварыг хөгжүүлж, тулгарсан асуудлаа гаргаж ирэх, шийдлийг шаардах, хариуцлага тооцох чадавхтай болоход нь дэмжлэг үзүүлэхийг эрмэлзэн;

Боловсролын тогтолцоог хүний мэдэх, бүтээх, хүний ёсоор хамтран амьдарч, нэр төртэйгээр оршиход суралцахуйц, хувь хүний потенциал, чадвар, чадавхыг нээж, зэрэг зан үйл, хандлагыг төлөвшүүлэхэд чиглэгдсэн, хүмүүнлэг, ардчилсан, хүн бүрийн эрхийг хангасан, тэгш хүртээмжтэй болгон өөрчлөхийг эрхэмлэн;

Хүүхэд, эцэг эх, багш, орон нутгийн бүлгүүд болон үндэсний, хэлний, соёлын, бэлгийн цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, орлого багатай иргэд зэрэг дуу хоолойгоо хүргэж, шийдвэр гаргахад оролцож чадахгүй байгаа бүлгүүдийг эрх мэдэлжүүлэх зорилгоор боловсролын тогтолцоо, бодлогод хяналт шинжилгээ, үнэлгээ хийх чадавхыг бүрдүүлэх, нөлөөлөх ур чадвараа дээшлүүлэх шаардлагыг ухамсарлан;

Хүний эрх, жендэрийн тэгш эрх, үл ялгаварлан гадуурхах, хүчирхийллээс ангид, хүлээцтэй байх, нээлттэй, ил тод, хариуцлагатай байх зарчмыг баримтлан;

Монгол улсад боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах, төсвийг хянах, хариуцлага шаардах, бодлогод нөлөөлөх үндэсний кампанит ажил зохион байгуулах зорилгоор эвсэн нэгдсэнээ тунхаглаж байна.

2010 оны 9 сарын 3

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН



**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН

**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН



УИН.МН  
СУДАЛГААНЫСАН